

С.БАЯРЫН ТЭРГҮҮЛСЭН  
ЗАСГИЙН ГАЗАР  
**100**  
ХОНОГТ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗАР

Улаанбаатар хот  
2008 он

**ЗАСГИЙН ГАЗАР 100 ХОНОГТ**

УИХ-аас баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ Ерөнхий сайд С.Баяр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг сайжруулах чиглэлээр нэн түрүүнд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаагаа тодорхойлж, иргэдийн төлөөллөө сонгох сонголт, байгалийн баялгийн ашиглалт түүний орлогын хуваарилалт, бүртгэлийн нэгдсэн тогтолцооны төгөлдөршилд хүрэх, төрийн албыг төгөлдөршүүлэх талаар дэвшүүлсэн үзэл санаа, хөндөж тавьсан асуудлыг шийдвэрлэх нь Монгол Улсад үүссэн хамгийн тулгамдсан асуудал гэж үзсэн.

Энэ хүрээнд Засгийн газар цаг хугацаатай уралдан ээлжит хуралдаанаас гадна асуудлын шаардлагыг харгалзан ажлын болон ажлын бус өдөр ээлжит бус хуралдааныг хийж, өндөр ачаалалтай, шуурхай ажиллаж байна.

## Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГА, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Засгийн газар энэ хугацаанд иргэдийн нийтлэг эрх ашгийг хөндсөн нэн тулгамдсан асуудлыг хугацаа алдахгүйгээр шийдвэрлэхийн зэрэгцээ бодлогын чанартай асуудлуудыг иргэд, мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллага, холбоодын саналыг сонсож, дэс дараатай шийдвэрлэх арга хэмжээ авч байна.

Төрийн албаны сахилга, хариуцлагыг сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлж байна. Монгол Улсад нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудыг цэгцлэн төрийн байгууллагуудад мөрдөгдөж байгаа иргэдэд чирэгдэл учруулсан, хүнд суртал бий болгосон, улсын бүртгэлд бүртгүүлээгүй дүрэм, журам, заавар тэдгээрийн заалтуудыг хүчингүй болгов.

Мөн ач холбогдлоо алдаж мөрдөхөө больсон, бусад хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, эх хувь нь байхгүйн улмаас мөрдөх боломжгүй болсон, хүчингүй болгохоор дүгнэлт гарсан боловч хүчингүй болгоогүй шийдвэрүүдийг цаашид мөрдөхгүй болгох чиглэлээр эрчимтэй ажиллав.

Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг бүх шатанд сайжруулах талаар Засгийн газрын албан даалгавар гарган хэрэгжүүлж байна.

Төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, зардлыг хэмнэх зорилгоор төрийн албанд хэрэглэгдэж байгаа том оврын жийп машин хотын дотор хэрэглэхийг зогсоож, төрийн албанд түлш бага зарцуулдаг, жижиг оврын автомашиныг тогтоосон нормын дагуу хэрэглэж байхаар шийдвэрлэв. Ингэснээр нийт 7.0 орчим тэрбум төгрөгийг улсын төсвөөс хэмнэх урдчилсан тооцоо гарсан байна. Мөн төсвийн зардлаар гар утас хэрэглэх явдлыг аль болох хязгаарлах зорилгоор холбогдох судалгааг хийж байна.

Мэргэжлийн хяналтын ажил үйлчилгээг иргэдэд илүү ойртуулах, үйлдвэрлэл, үйлчилгээний цэг, объектод шуурхай хүртээмжтэй хүрч ажиллах үүднээс бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, мэргэжлийн хяналтын төв аппаратад 333 хүн ажиллаж байсныг 80 болгож, улсын хяналтын 10 алба байсныг 7 болгон цөөрүүлж, нийслэлийн дүүргүүдэд мэргэжлийн хяналтын нэгжтэй байхаар шийдвэрлэн хэрэгжүүлж байна. Улсын мэргэжлийн хяналтын газарт хийсэн бүтцийн өөрчлөлтөөр удирдлагын шат дамжлага багасч, төвлөрөл сааран, мэргэжлийн хяналтын төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, хяналт шалгалтын давхардлыг багасгаж чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөл боломж бүрдэж байна.

Мөн Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийг өөрчилж нэгжийг цөөрүүлэн, цомхон, шуурхай ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авлаа.

Хөдөөд суурьшин амьдарч буй иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг дээшлүүлэхэд чиглэсэн “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг батлан 2008-2015 он хүртэл хугацаанд 3 үе шаттай хэрэгжүүлэх ажлыг эхлээд байна. Уг хөтөлбөрийн 1 дүгээр үе шат буюу 2008-2010 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардлагатай хөрөнгийн тооцоог гарган нийт зардлын 30 хувийг улсын төсвөөс, 70.0 хувийг орон нутгийн төсвөөс гаргахаар төлөвлөн ажиллаж байна. Багт ажиллах хүний эмч, түүний унаа, эмнэлгийн хэрэглэлийн норматив, багийн сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын болон сургууль завсардсан хүүхдэд бичиг үсгийн боловсрол олгох журам, багт байгаль орчныг хамгаалах үйлчилгээ, байгаль хамгаалагч ажиллуулах норматив зэргийг орон нутгийн онцлогт тохируулан боловсруулж байна. Сум бүрд загвар баг бий болгох, бүх багийг эм, эмнэлгийн хэрэгсэлээр хангах, холбооны техник хэрэгсэлүүдийг засварлан ажилд оруулах ажлыг 2008 онд бүрэн хэрэгжүүлнэ.

Аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарын хамтарсан семинарыг 2007 оны 12 дугаар сард зохион байгуулж Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх асуудлаар чиглэл өгч, орон нутгаас 2008 онд нийлүүлэх бүтээгдэхүүний гэрээг байгуулав. Мөн 2008 оны 3 дугаар сард аймгийн Засаг дарга нарын нэгдсэн уулзалтыг зохион байгуулж, боловсролын тогтолцоог төгөлдөршүүлэх талаар Засгийн газраас баримталж буй бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг хугацаанд нь хэрэгжүүлэх үүрэг, чиглэл өгөн ажиллаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад байгаа 500.0 саяаас доош өртөгтэй хөрөнгө оруулалт, их засварын ажлын санхүүжилтийн эрхийг орон нутагт шилжүүлж, хөрөнгө оруулалтын ажлын хугацаа, чанар, зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг өндөржүүлэх зорилгоор аж ахуйн тооцоон дээр ажиллах Хот байгуулалт, барилга захиалагчийн албыг бүх аймгуудад байгуулан ажиллуулж байна.

Сумдын Засаг дарга нарт төрийн захиргааны онол, төрийн албаны шинэтгэлийн хүрээнд менежментийн сэтгэлгээний шинэчлэл, орчин үеийн хандлагын талаар шинэ мэдлэг олгох зорилгоор Удирдлагын академи дээр бүх сумдын Засаг дарга нарын сургалтыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Хөвсгөл, Дархан-Уул, Дорноговь, Говьсүмбэр, Дундговь аймгуудад ажиллаж 9 сум, 20 гаруй байгууллагын ажилтай танилцан ажил төрлийн зөвлөгөө өгч, 3000 гаруй иргэдтэй уулзаж Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний талаар танилцуулж, тэдний санал бодлыг нь сонсов. Мөн Замын-үүд сумын статус болон сумын хөгжлийн асуудлууд, тэнд ажиллаж буй хил, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудын өмнө тулгарч байсан асуудлуудыг шийдвэрлэв.

Монгол Улсын төрийн байгууллага, төрийн албан хаагчийн 2007 оны тоо бүртгэлийн дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, цаашид төрийн албыг төгөлдөршүүлэх зорилтыг тодорхойлоход анхаарлаа хандуулан ажиллаж байна.

## Хоёр. НИЙГМИЙН БОДЛОГЫН ТАЛААР

### Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт

Засгийн газар иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хэрэглээний үнийн индексийг тогтворжуулан, инфляцийг бууруулж, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг өсгөн, өрхийн хэрэглээгээ бүрэн хангаад зогсохгүй хуримтлал үүсгэх боломжтой болгох зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа билээ.

**Үнийн өсөлтийг саармагжуулах, тогтворжуулах чиглэлээр Засгийн газар өөрийн эрх мэдлийн хүрээнд онцгой анхаарч ажиллаж ирэв.** Засгийн газрын тогтоолоор Үнийг тогтворжуулах хөтөлбөр, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

Өнгөрсөн хугацаанд Үнийг тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр зохиосон ажлын явцыг Засгийн газрын хуралдаанаар зургаан удаа хэлэлцэж, тухай бүр тодорхой арга хэмжээ авч ирэв. Тухайлбал, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2007.12.20) болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай” Улсын Их Хурлын (2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 96 дугаар) тогтоолыг батлуулж, 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд импортолж борлуулсан хүнсний улаан буудай болон импортлон борлуулсан 40.0 мянган тонн буудайн гурилын нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татварын хувь хэмжээг тэг (0) хувьтай тэнцүү байхаар тогтоон хэрэгжүүлж байна.

Улсын дүнгээр 2008 оны хавар борлуулах 8.0 мянган тонн (нийслэлд 7.0 мянган тонн) махыг нөөцлөх, мах нөөцөлсөн компаниудын банкны зээлийн хүүгийн төлбөрт олгох 3.0 тэрбум төгрөгийн асуудлыг шийдээд байна.

2008 оны улсын төсөвт нөхөн төлбөрт зориулан 8.6 тэрбум төгрөг тусгагдсанаас нийтийн зорчигч тээврийн билетийн үнийг тогтвортой байлгах зорилгоор 2007 оны 12 дугаар сард 1.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг нийтийн тээврийн байгууллагад олгосон.

Засгийн газрын 2007 оны 357 дугаар тогтоолын дагуу 2007 оны 11 дүгээр сарын үнээр борлуулсан шатахууны үнийн зөрүүд нефть импортлогч холбогдох аж ахуйн нэгжүүдэд улсын төсвөөс 3.5 тэрбум төгрөгийн татаас олгох тухай Сангийн сайдын шийдвэр гарган хэрэгжүүлж байна. Энэ нь цаашид байнга хэрэглэх арга биш ч тодорхой хугацаанд үнийн өсөлтийг хязгаарласан арга хэмжээ боллоо.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2007.12.21), Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2007.12.21) хуулийг батлуулж, газрын тосны бүтээгдэхүүний онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын төлөлтийг нэг сараар хойшлуулах, мөн компаний нөөц бүрдүүлэх зорилгоор импортолж байгаа газрын тосны бүтээгдэхүүний онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварыг уг бүтээгдэхүүнийг борлуулах хүртэл хугацаагаар хойшлуулах ажлыг зохион байгуулж байна.

Газрын тосны бүтээгдэхүүний гадаад хүчин зүйлээс шалтгаалсан үнийн өсөлтийг Засгийн газраас шуурхай зохицуулж байх зорилгоор татвараас чөлөөлөх, түүний хувь хэмжээг хөнгөлөх, өсгөх, татвар төлөх хугацааг түр

хойшлуулах эрхийг Засгийн газарт олгох чиглэлээр Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн мэдүүлээд байна. Эдгээр хуулиудад өөрчлөлт оруулснаар Засгийн газар газрын тосны бүтээгдэхүүний онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн тарифыг хуульд заасан хязгаарт багтаан богино хугацаанд шуурхай зохицуулах бололцоотой болох юм.

Эх орны хишиг сангийн тухай хуулийн төсөл, Монгол Улсын төсвөөс 2008 онд Монгол Улсын иргэдэд хуваарилах мөнгөний хэмжээг тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслийг тус тус боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн өргөн барихаар бэлтгэж байна.

Монгол улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох зорилгоор Үндэсний хөтөлбөрийг батлан тодорхой ажлуудыг эхлээд байна. Энэ хөтөлбөр хэрэгжиж Монгол улс бүртгэлийн нэгдсэн тогтолцоотой болсноор төр, иргэдийн хэлхээ холбоог бэхжүүлэх, улс орны эдийн засгийн хөгжилд мэдрэгдэхүйц түлхэц өгөх нөхцөл боломж бүрдэх болно.

Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барив.

Төрийн албан хаагчдын цалинг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 28.5 хувиар нэмэгдүүлэв. Уг арга хэмжээнд 129773 төрийн албан хаагч болон 18712 гэрээт ажилчин хамрагдаж байгаа бөгөөд 2008 оны суурь цалингийн сан 109.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 556.9 тэрбум төгрөг болж төрийн албан хаагчдын дундаж цалин 300.0 мянган төгрөгт хүрлээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 108.0 мянган төгрөгөөр тогтоож, нөхөн олговрын доод хэмжээг 81.0 мянган төгрөг болгов.

Төрийн албан хаагчийн цалинг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд улс төрийн албан тушаал эрхэлдэг баг, хороо, сум, дүүргийн Засаг даргын албан тушаалын цалингийн жишгийг тухай бүр шинэчлэн тогтоох арга хэмжээ авлаа. “Төрийн өндөр албан тушаалын болон түүнтэй адилтгах албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” асуудлыг боловсруулж, УИХ-аар шийдвэрлүүлж ажиллав.

Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг УИХ-аар батлуулав. Хуулийн төсөлд нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, даатгалын хамрах хүрээг өргөтгөх, ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээг бууруулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоох, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлыг тусгалаа.

Нийгмийн даатгалын сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх, ачааллыг багасгах зорилгоор ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээг 19.0 байсныг 10.0 хувь болгон бууруулах арга хэмжээ авлаа. Ингэснээр аж ахуй нэгж байгууллагын эдийн засгийн чадавхийн өсөлтийг дэмжих, ажлын байр болон ажиллагсадын цалинг нэмэгдүүлэх алхам болсон гэж үзэж байна.

Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-аар батлуулав. Хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор 2008 онд 15.1 тэрбум төгрөг нийгмийн халамжийн сангаас олгогдоно.

Нийгмийн халамжийн багц хуульд өөрчлөлт орсноор хөдөлмөрийн чадвараа 50-70 хүртэл хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэжээгч нь нас барсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд, бүтэн өнчин хүүхэд, ихэр хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээнд хамруулах эрх зүйн орчин шинээр бий боллоо. Тухайлбал, 16 хүртэлх насны 4 хүүхэдтэй өрх толгойлсон 45 настай эх, 50 настай эцэг, халамжийн тэтгэвэрт хамрагдах болов.

1995 оноос өмнө цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтоолгосон иргэнд 1.0 сая төгрөгний буцалтгүй тусламжийг олгох асуудлыг УИХ-аар шийдвэрлүүлэв. Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох арга хэмжээнд шаардагдах 6.0 тэрбум төгрөгийг 2008 оны төсөвт тусган 2008 оны 4 дүгээр сарын 1-ний дотор олгохоор төлөвлөөд байна.

### **Эрүүл мэндийн салбарт**

Эрүүл мэндийн салбарын 1300 гаруй эмч, ажиллагсдын төлөөллийг оролцуулсан цуврал уулзалтууд нээлттэй, ажил хэрэгч уур амьсгалд болж, бүгд 71 багц асуудлын тухай санал гаргаж тэдгээрийн мөрөөр төлөвлөгөө гарган ажиллаж байна. **“Үйлчлүүлэгчид ээлтэй эрүүл мэндийн тусламж”** уриан дор салбарын удирдах ажилтны зөвлөлгөөнийг зохион байгуулж, зөвлөлгөөнөөр “Эрүүл мэндийн салбарын 2007 оны үйл ажиллагааны үр дүн, зөвлөмжүүд”, “2008 он - Үйлчлүүлэгчид ээлтэй эрүүл мэндийн тусламж” асуудлуудыг хэлэлцэж, П.Н.Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Арьсны өвчин судлалын төв, Улсын клиникийн төв эмнэлэг, Хавдар судлалын төвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн тусламж

үйлчилгээний тэргүүн туршлагатай газар дээр нь танилцаж санал бодлоо солилцов.

Багийн хүний эмчийн унаа, эм, эмнэлгийн багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцасны шинэ нормд зааснаар багийн эмч бүрт 83 нэрийн эм, хэрэгсэл, мотоцикль 1, унааны морь 4, нэн шаардлагатай 49 нэрийн багаж тоног төхөөрөмжтэй байх, эм хэрэгслийн хангалтыг сар бүр, хөдөлмөр хамгааллын хувцас, унааны морь, мотоциклийн нөхөн хангалтыг 2-4 жил тутам хийж байхаар шийдвэрлэлээ.

Засгийн Газар улсын хэмжээнд аюулгүй, чанарын баталгаатай цус, цусан бүтээгдэхүүнээр эмнэлгийн байгууллагыг хангах, болзошгүй гамшиг, ослын үеийн хүрэлцээтэй нөөцийг тасралтгүй бүрдүүлэх зорилгоор “Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, хангамжийг сайжруулах талаар төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталлаа.

Орхон аймагт Бүсийн оношлогоо эмчилгээний төвийг аймгийн нэгдсэн эмнэлгийг түшиглэн байгуулж, шаардлагатай оношлогоо эмчилгээний тоног

төхөөрөмжийг шинэчлэхэд 400,0 сая төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангаас гаргахаар боллоо.

Орон нутгийн хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд тусламж үйлчилгээ үзүүлэх сонгон шалгаруулалтад тэнцсэн, улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг тусламж үйлчилгээний багцаас давхардуулалгүйгээр санхүүжилтийг олгох, гүйцэтгүүлэх харилцааг зохицуулах зорилгоор “Улсын төсөв болон даатгалын сангийн санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгох, гүйцэтгүүлэх журам”-ыг боловсруулав.

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар “Сум /тосгон/, сум дундын эмнэлгийн санхүүжилтийн аргачлал батлах тухай”, мөн аймаг, нийслэлд үйл ажиллагаагаа явуулж буй өрхийн эмнэлгүүдийн 2008 онд мөрдөх “Өрхийн эмнэлгийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн хэмжээ”-г баталлаа.

**Халдварт өвчний эсрэг үйл ажиллагаа эрчимжив.** Халдварт өвчнөөс сэргийлэх вакцины хадгалалт, тээвэрлэлтийн горимыг шалгаж, илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ авч, аймаг, сумын дархлаажуулалтын вакцины хадгалалтад хяналт, шалгалт хийх удирдамж гаргав. Улмаар вакцинжуулах сувилагчдын бүсийн сургалт хийх хөтөлбөрийг боловсруулж бэлтгэлийг хангалаа. Халдварт өвчний 2020 он хүртэлх хөдлөл зүйг боловсруулах ажлын хэсэг томилж, одоогоор 2011 он хүртэлх хугацааны хандлагыг тодорхойлоод байна.

Эхийн эндэгдлийн асуудлаар үндэсний зөвлөлгөөнийг зохион байгуулав. Энэхүү зөвлөгөөн нь эсэн мэнд амаржихуйн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, эрүүл мэндийн чиглэлийн мэдээллийг нийтийн зах зээлд нэвтрүүлэхэд төрийн байгууллагуудын хүчийг нэгтгэх, бизнесийн байгууллагууд болон иргэний нийгмийн оролцоог дайчлахад туршлага болсон ач холбогдолтой зөвлөгөөн боллоо.

“Дэлхийн хүүхдийн байдал 2008” тайлан илтгэлийг хүлээн авах ёслолын арга хэмжээг зохион байгуулав. Мөн аймаг, дүүргийн хүүхдийн ерөнхий мэргэжилтнүүдийн ээлжит зөвлөгөөнийг зохион байгуулж 2007 оны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, нөхцлийг хэлэлцэн цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Дархан-Уул аймгийн Хонгор суманд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Монгол улсын Засгийн газраас Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад тавьсан хүсэлтийн дагуу олон улсын шинжээчдийн 9 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж ажиллаж урьдчилсан дүнгээ гаргав.

**Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийв.** Ховд, Өвөрхангай аймгийн Бүсийн оношлогоо, эмчилгээний төв /БОЭТ/, Орхон, Хөвсгөл, Завхан аймгийн нэгдсэн эмнэлэгт 10 нэрийн 533.1 сая төгрөгийн үнэ бүхий дижитал уян дурангийн иж бүрдлийг, Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Улсын клиникийн төв эмнэлэг, Клиникийн нэгдсэн 2 дугаар эмнэлэг, Эх нялхсын эрдэм шинжилгээний төвд 982,7 сая төгрөгийн үнэ бүхий дижитал рентген аппарат, зураг угаагчийн хамт, Хавдар судлалын үндэсний төвд 67,1 сая төгрөгийн үнэтэй рентген, маммограф аппарат, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, Ховд

аймгийн БОЭТ-д 1106,9 сая төгрөгийн үнэ бүхий телевизийн системтэй суурин рентген аппаратыг тус тус нийлүүлэв.

Мөн 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, 8 дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, нийслэлийн 3 төрөх газарт 210.0 сая төгрөгийн лабораторийн анализатор, шинээр ашиглалтад орсон Төв аймгийн Мөнгөнморьт, Увс аймгийн Өлгий, Ховд аймгийн Алтай, Дундговь аймгийн Говь-Угтаал, Сүхбаатар аймгийн Халзан сумын эмнэлгүүдэд 10 нэр төрлийн 25,2 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн техник хэрэгсэл, “Эрүүл монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 200 сумын эмнэлэгт 10 нэр төрлийн 367,6 сая төгрөгийн лабораторийн техник, хэрэгсэлийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус тус олгож суурилуулан ашиглалтад оруулав.

Нийслэлийн Яаралтай тусламжийн төв, Сонгинохайрхан, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдийн эрүүл мэндийн нэгдэл, ХӨСҮТ, Клиникийн нэгдсэн 2 дугаар эмнэлэг, Дорнод аймгийн Халх гол сумын эмнэлэг дуудлагын шаардлага хангасан KZ-6490 маркын 334,0 сая төгрөгийн өртөг бүхий 18 авто машинаар парк шинэчлэв.

Хөдөө орон нутагт стандартын шаардлага хангахгүй байгаа судсаар сэлбэх шингэнийг эмнэлэгт бэлтгэхийг зогсоосонтой холбогдон нэмэлтээр эмийн төсөвт шаардагдах 830,4 сая төгрөгийг 2008 оны төсөвт тусгав.

Эрхтэн шилжүүлэн суулгасан иргэдэд төрөөс үнэ төлбөргүй олгож буй Програф эмийн хангамжийн талаар үйлдвэрлэгч Япон улсын Астеллас компанитай Улсын клиникийн төв эмнэлгийг шууд гэрээ байгуулуулж уг эмээр хангах болсноор улсын төсвөөс 300.0 орчим сая төгрөгийг хэмнэх боломж бүрдлээ.

ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх дэлхийн “Глобаль” сан Монголын сүрьеэ өвчтэй хүмүүсийн эмэн эмчилгээний санхүүжилтийг дагнан хариуцаж байсан системийг өөрчлөн дэлхийн сүрьеэгийн эмийн сүлжээгээр дамжуулан чанарын баталгаатай үйлдвэрээс нь 2008 оноос эхлэн Монгол улс анх удаа бие даан сүрьеэгийн эмийг хангаж эхэллээ. Ингэснээр үйлчлүүлэгчдэд чанартай, баталгаатай сүрьеэгийн эмээр тасралтгүй хангах боломж бүрдэж байна.

Бага насны хүүхдийн вакциныг НҮБ-ын Хүүхдийн сангийн сүлжээг ашиглан үйлдвэрлэгчдээс шууд авахаар боллоо. Ингэснээр Монголын хүүхэд багачуудыг чанартай, баталгаатай, стандартад нийцсэн вакцинаар хангах, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх боломж бүрдлээ. НҮБ-ын Хүүхдийн сангийн 500.0 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр вакцин, био бэлдмэлийг стандартын дагуу зөв хадгалах, хүйтэн хэлхээний нэгдсэн агуулахыг барьж ашиглалтад оруулав.

Менинкоккын халдварын тархалт 2008 оны 5, 6 сард нэмэгдэх хандлагыг угтуулж 2-14 насны 473.0 мянган хүүхдэд энэ халдвараас урьдчилан сэргийлэх 907.0 сая төгрөгийн үнэ бүхий вакциныг захиалаад байна.

**Бээжин 2008 олимпийн бэлтгэл ажил эрчимжлээ.** Бээжин 2008 зуны олимпийн 29 дүгээр наадамд оролцох Монголын баг тамирчдын 22 төрлийн хувцасыг захиалж гэрээ байгуулах ажил хийгдэж байна. 2007 онд спортын өндөр амжилт гаргаж тив, дэлхийн тэмцээнээс алт, мөнгө, хүрэл медаль авсан тамирчдад 180.0 сая төгрөгийн мөнгөн шагнал олгов.

Монгол улсын Эрүүл мэндийн яам, Дэлхийн Зөн Монгол-Олон улсын байгууллага хоорондын 2008-2012 онд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав.

Азийн хөгжлийн банкны 14.0 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжих “Эрүүл мэндийн салбарын хөгжил-3” төслийг хэрэгжүүлэх талаар Сангийн сайд АХБ-ны суурин төлөөлөгч нар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав. Төсөл нийслэлийн хоёр дүүрэг, таван аймгийг хамран 5 жилийн хугацаанд хэрэгжих юм.

### **Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт**

“Монгол Улсад Инновацийн тогтолцоог хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулж, төр-шинжлэх ухаан-бизнесийн төгөлдөршүүлэлтийн бодлого, зорилтоо тодорхойлон хэрэгжүүлж эхлэв. Шинжлэх ухааны ажилтны Улсын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулж зөвлөмж гаргалаа.

“Сургуулийн өмнөх боловсрол-2” үндэсний хөтөлбөрийг 2001-2007 онд хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хөтөлбөр хэрэгжсэнээр сургуулийн өмнө боловсролын хамран сургалт 2001-2007 онд 23.5 хувиар өсч, 57.1 хувьд, мэргэжлийн багшийн хангалт 93.3 хувьд хүрч 0.7 хувиар тус тус өссөний гадна улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээ 29.1 тэрбум төгрөг болж, 2005 оныхоос 18.3 хувиар нэмэгдэв.

Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх, 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэх бэлтгэл ажлын 60 хувийг гүйцэтгээд байна. Азийн хөгжлийн банк, Нордикийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Боловсролын хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд нийт 376.0 мянган ам доллар буюу 440.0 гаруй сая төгрөгийн санхүүжилтээр тус бүр 2 анги буюу 300 бүлгийг иж бүрэн тохижуулах 1, 2 дугаар ангийн сурагчийн болон багшийн ширээ, сандал, самбар, DVD, телевизор болон бусад шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүнийг ерөнхий боловсролын 150 сургуульд хүлээлгэн өгөв. Үлдсэн 1450 бүлэгт шаардагдах тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд шаардагдах 2.0 тэрбум төгрөгийг 2008 оны төсвийн тодотголд тусгаад байна.

Монгол Улсын суурь боловсролын сурлагын амжилтад шинжилгээ, үнэлгээ хийж, цаашдын чиглэл, авах арга хэмжээг тодорхойлов. Үнэлгээнд аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын 6, 9 дүгээр ангийн 3840 сурагч, 3840 эцэг эх, 576 багш, 96 удирдах ажилтныг хамруулан судалгаа, шинжилгээ хийж, оновчтой боловсруулсан төстийн аргаар сурлагын амжилтыг үнэлж дүгнэн, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж, хамаарлыг тогтоон авах арга хэмжээг тодорхойлсон нь чухал ач холбогдолтой боллоо.

Сурлагын онцгой амжилт гаргасан суралцагчдад Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын нэрэмжит шагнал олгох журмыг Засгийн газар баталж, сурагч, оюутныг дэмжих шинэ боломжийг бүрдүүллээ. Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт 3.0-аас дээш голч дүнтэй суралцаж, олон улсын спорт, урлагийн улсын аварга шалгаруулах уралдаан тэмцээн, техник технологи, илтгэлийн уралдаанд эхний 3 байр эзэлсэн, Ерөнхий сайдын тэтгэлэгт 3.8-аас дээш голч дүнтэй суралцаж, олон нийтийн ажилд идэвхтэй оролцож буй зэрэг заагдсан шалгуурыг хангасан дотоодын их, дээд сургуулийн оюутан, магистрант, докторант хамрагдана. Ерөнхийлөгчийн

нэрэмжит тэтгэлгийг жилд 30 хүртэлх хүүхдэд 100.0 мянган төгрөг, Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийг 50 хүртэлх хүүхдэд 80.0 мянган төгрөгийг тус тус 10 сарын хугацаатай сар бүр олгоно.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Энхбаярын АНУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр гарын үсэг зурсан “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийг эхлүүлж нийслэлийн Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 51 дүгээр сургууль, Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, Төв аймгийн Баян сумын 9 жилийн сургуулийн 2-5 дугаар ангийн нийт 1000 сурагчдад зөөврийн компьютер гардууллаа. Хөтөлбөр хэрэгжснээр сургууль бүр интернетэд холбогдож, компьютер сурагчдын өдөр тутмын хэрэглээ болж, улмаар мэдээллийн технологийг сургалтад нэвтрүүлэх, хүүхэд бүр и-мэйл хаягтай болох зэргээр үр дүн нь хэрэглэгч, хүүхэд бүрт шууд хүрч байна. 2007-2008 оны хичээлийн жилд 25000 сурагчдыг дээрх хөтөлбөрт хамруулна.

Азийн хөгжлийн банкны 13.0 сая долларын санхүүжилттай “Боловсролын хөгжлийн хөтөлбөр-3” төслийн шугамаар 150 сургуулийг 6 настай хүүхдийн ширээ, сандал, сургалтын тоног, төхөөрөмж бүхий мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн загвар 2 төвийг байгуулахад 577.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийв.

Ерөнхий боловсролын болон багш бэлтгэдэг 192 сургуульд 3.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр тус бүр 21 компьютер, LCD, принтер бүхий зайны сургалтын лаборатори шинээр байгуулсны зэрэгцээ аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газарт 122.0 сая төгрөгийн электрон самбарыг нийлүүлж, сургалт явуулах орчныг сайжрууллаа.

Их, дээд сургуулийн тогтмол зардлыг төрөөс санхүүжүүлдэг болж, анх удаа дээд боловсролд бодитой хөрөнгө оруулалт хийв. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн нэг суралцагчид 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс сар бүр 45000 төгрөгийн тэтгэлгийг олгож эхэлснээр зах зээлд эрэлттэй мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчин бэлтгэхэд дорвитой түлхэц үзүүлэв.

Шинжлэх ухаан, технологийн их сургууль 2007-2008 оны хичээлийн жилээс “Нээлттэй их сургууль”-ийг байгуулан 13 мэргэжлээр магистрийн зэрэг олгож, 52 хичээлийг зайнаас явуулах болсноор тухайн суралцагч ажлын байрнаасаа хөндийрөхгүйгээр долоо хоногийн 24 цагийн турш суралцах боломжтой болов. Одоогоор энэ сургалтад 120 гаруй магистрант суралцаж байгаагийн дотор гадаад улс, оронд /БНХАУ, Япон, БНСУ/ ажиллаж амьдарч байгаа 5 суралцагч байна.

“Соёл, урлаг-Хүний хөгжилд” аян, “Соёл, урлагийн ажилтны Улсын анхдугаар чуулган”-ыг зохион байгуулж зөвлөмж гарган хэрэгжүүлж эхлэв. Уг чуулганаар зах зээл, иргэний ардчилсан нийгэмд шилжсэнээс хойшхи 16 жилийн туршлага, сургамж, ололт амжилт, соёл урлагийн өнөөгийн байдалд үнэлэлт өгч, хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлов.

Улсын төсвийн хөрөнгөөр 2008 онд соёл, урлагийн байгууллагуудад нийт 1.536.1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх болсон нь өмнөх жилийнхээс 20 дахин илүү байна. Нийт 21 аймгийн 326 номын санд нэг сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар номын фондыг баяжуулж, 200-аад соёлын төвд нийт 251.0 сая төгрөгийн 195 ширхэг /4 төрлийн/ үндэсний хөгжмийн багц, 279.0 сая төгрөгийн орчин үеийн даралтат хөгжим, өсгөгчийн иж бүрдэл, Дуурь бүжгийн эрдмийн театр, Улсын филармонид нийт 150.0 сая төгрөгийн их гарын төгөлдөр хуурыг тус тус нийлүүлэв. Энэ нь хүн амд хүргэх соёл, урлагийн

үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, уран бүтээлчдийн ажиллах нөхцлөөр хангахад чухал ач холбогдолтой юм.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрт Монгол дахь Францын соёлын төвтэй хамтран “Севилийн үсчин” дуурийг шинэчлэн, Румыны зохиолч Себестьяны “Нэргүй од” драмын жүжгийг шинээр тавьсаны зэрэгцээ Б.Лхагвасүрэнгийн зохиол “Сарны цагаан цус” жүжгийг Улсын Драмын тайзнаа тавьж, үзэгчдийн хүртээл болгоход 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

Монголд анх удаа олон улсын сонгодог хөгжмийн үдэшлэг, балетийн гала концерт, дэлхийн нэртэй орчин үеийн дуунуудыг дуурийн найрал дууны төрөлд шилжүүлэн тоглолт хийж үзэгчдэд шинэ, соргог уран бүтээлээр бэлэг барьсан нь сонгодог урлагийг эх орондоо хөгжүүлэх, уран бүтээлчдийн чадварыг сорьж үзэгчдэд шинэ хэлбэрийн бүтээлийг хүргэсэн арга хэмжээ болов.

#### Гурав. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТАЛААР

**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хамгийн том зорилтуудыг дэвшүүлсэн баримт бичиг боллоо.** Үндсэн чиглэлийг УИХ-ын (2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн) нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд ДНБ-ний өсөлтийг 10.1 хувь, бараа, үйлчилгээний үнийн өсөлтийг 6.0 хувь байлгахад тооцож, төсвийн байгууллагын албан хаагчдын цалинг 20 хувиар, өндөр настны тэтгэврийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан байна.

Мөн үндсэн чиглэлийн хүрээнд инфляцыг тогтвортой байлгах, хүнсний хангамжийг сайжруулах, мах, сүү, гурил, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гол зорилтыг хангахад чиглэгдэж байна. Түүнчлэн сумдад ажлын байр нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх, өрсөлдөх чадвартай үйлдвэрлэлийг дэмжих, тэргүүний шинэ техник, технологийг нэвтрүүлэх, уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэх, бүсийн төв, томоохон хотуудад үйлдвэрлэл технологийн парк байгуулах зорилгоор олон улсын санхүүгийн зах зээлд 1.2 тэрбум ам.доллар хүртэл хэмжээтэй Засгийн газрын бондыг борлуулж, мөн санхүүгийн бусад эх үүсвэрийг дайчлан 300.0 хүртэл сая ам.долларыг зарцуулах, улмаар Эрдэнэтийн зэсийн баяжмалыг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эхлэлийг тавих зэрэг томоохон зорилтыг дэвшүүлэв.

**Манай улсын эдийн засаг, санхүүгийн байдал сайжирч, эдийн засгийн бодит өсөлтийг тогтвортой хадгалах түүхэн боломж нэмэгдэж байна.** Засгийн газар эдийн засаг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, төсвийн орлогын баазыг өргөжүүлэх, төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх, улсын санхүүгийн нөөцийг арвижуулах, үндэсний үйлдвэрлэлийг мөнгө, татварын бодлогоор дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангах, иргэдийн худалдан авах чадварыг сайжруулахад түлхүү анхааран ажиллаж байна. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт сайжирч, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл (оны үнээр) 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр **4557.5** тэрбум төгрөгт хүрлээ. Эдийн засгийн бодит өсөлт 2007 онд 9.9 хувьд хүрч, 2006 оныхоос 1.4 нэгжээр ахиж, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ **1480** ам. долларт хүрэв. Дэлхийн зах зээлд алт, зэсийн үнэ өндөр

байсан, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн, малын тоо толгой ихээхэн өссөн явдал бараа, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтэд эерэгээр нөлөөлж, эдийн засгийн өсөлтөд ихээхэн дэмжлэг үзүүллээ. Гэсэн ч хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын өсөлт 2007 онд 15.1 хувьд хүрч 2006 оныхоос 9.1 нэгжээр нэмэгдэн хүн амын худалдан авах чадварт сөрөг нөлөө үзүүлж болзошгүйд онцгой анхаарал тавин ажиллаж байна.

**2008 он Монгол Улсын түүхэнд хамгийн их хэмжээний төсвийг батлуулсан жил боллоо.** Монгол Улсын төсвийн цар хүрээ өргөжихийн хэрээр түүний бүтцэд агуулгын өөрчлөлт орсноор эдүгээ улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв, нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрддэг боллоо. Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар дөрвөн удаа хэлэлцүүлж, улмаар УИХ-ын (2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн) нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2008 оны төсвийн тухай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуулийг баталсан юм.

Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн нийт орлогын доод хэмжээг **1,718.1** тэрбум төгрөгөөр, улсын төсвийн нийт зарлагын дээд хэмжээг **1,946.6** тэрбум төгрөгөөр баталсан байна. Монгол Улсын төсвийн 2008 оны урсгал тэнцлийг 655.0 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцлийг 137.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тооцсон нь ДНБ-ний 2.5 хувьтай тэнцэж байна. Мөн Монгол Улсыг хөгжүүлэх санд 2008 онд төвлөрүүлэх орлогын доод хэмжээг 363.3 тэрбум төгрөгөөр, сангийн зарлагын хэмжээг 339.7 тэрбум төгрөг (хөрөнгө оруулалт, их засварын зардлын хэмжээг 235.1 тэрбум төгрөг, хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжид 104.6 тэрбум төгрөг)-өөр, Нийгмийн даатгалын санд 2008 онд төвлөрүүлэх орлогын доод хэмжээг 299.3 тэрбум төгрөгөөр, сангийн зарлагын хэмжээг 428.4 тэрбум төгрөгөөр тус тус баталсан байна.

**Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн алдагдлыг бууруулах ажлыг оновчтой удирдлагаар хангаж ажилласны дүнд Монгол Улсын нэгдсэн төсөв зах зээлийн эдийн засгийн харилцааны шилжилтийн сүүлийн 17 жилийн явцад гурав дахь удаагаа ашигтай гарсан нь манай орны цаашдын хөгжилд ихээхэн түлхэц болно гэж үзэж байна.** Монгол Улсын нэгдсэн төсөвт 2007 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нийт орлого **1851.2** тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг **147.2** тэрбум төгрөгөөр буюу 8.6 хувиар давуулан биелүүлж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 490.8 тэрбум төгрөгөөр буюу 36.2 хувиар илүү байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага 2007 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр **1749.2** тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн нийт зарлагын 96.3 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 512.3 тэрбум төгрөгөөр буюу 41.4 хувиар илүү байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2007 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр урсгал тэнцэл **482.2** тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл **102.2** тэрбум төгрөгийн ашигтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 411.7 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 97.9 тэрбум төгрөгийн ашигтай) гарсан байна. Үүний дүнд 2007 оны урсгал тэнцлийн ашиг ДНБ-ний 10.7 хувьтай, нийт тэнцлийн ашиг ДНБ-ний 2.3 хувьтай тэнцэхүйц хэмжээнд хүрсэн байна.

**Улсын төсвийн ба Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2007 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хэмжээ өмнөх оныхоос даруй 2.7 дахинаар өссөн дүнтэй гарлаа.** Улсын төсвийн ба Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2007 оны хөрөнгө оруулалтын санхүүжилт **366.3** тэрбум төгрөгт хүрч, 2006 оныхоос **2.7** дахин нэмэгдсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2007 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 204.5 тэрбум төгрөг (барилга байгууламжид 132.1 тэрбум төгрөг, их засварт 18.5 тэрбум төгрөг, тоног төхөөрөмжид 46.7 тэрбум төгрөг, авто замын санхүүжилтэд 7.2 тэрбум төгрөг)-ийн санхүүжилт олгосон бөгөөд жилийн төлөвлөгөөтэй харьцуулахад 92.1 хувьтай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 161.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлж, нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 87.4 хувьтай гарч байна.

**Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг зөв харьцаатай болгох, тэдний суурь цалинг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд салбарын цалингийн сүлжээг шинээр тогтоож, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан нь нийгмийн сэтгэл зүйд чухал үр нөлөөтэй ажил боллоо.** Засгийн газар 2008 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 108000 төгрөгт, төрийн албан хаагчийн сарын дундаж цалинг 300000 төгрөгт, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 81000 төгрөгт, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 54000 төгрөгт хүргэж, нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлэх арга хэмжээ авснаар төрийн албан хаагчдын болон иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд чухал түлхэц үзүүлж байна.

**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2008 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хамгийн олон буюу 453 төрлийн арга хэмжээг Засгийн газар батлан хэрэгжүүлж эхлээд байна.** Засгийн газраас ойрын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээг нэгтгэн иж бүрэн төлөвлөгөө болгон Засгийн газрын тогтоолоор батлав. Эдгээр зорилт, арга хэмжээ нэг бүрийг хариуцан хяналт тавих Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарыг нэр заан баталж, үүрэг өгөөд байна.

**Засгийн газрын мөнгөн хөрөнгийн төлөвлөлт, удирдлага, зохицуулалт сайжирч, улсын төсвийн орлогын бүрдүүлэлтийн түр саатлаас шууд хамааралгүйгээр улсын төсвийн урсгал ба хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх хөрөнгийн боломж өсөн нэмэгдэж байна.** Батлагдсан урсгал төсвийн хуваарийн дагуу 2007 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр (өссөн дүнгээр) нийт **838.4** тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2007 оны эхнээс **85.2** тэрбум төгрөгөөр буурч, 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар **314.8** тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэхүү төрийн сангийн мөнгөн хөрөнгийн сул чөлөөт эх үүсвэрээс Монголбанк, арилжааны банкуудад төгрөгийн ба валютын богино хугацаат хадгаламж байршуулж, улсын төсөвт хүүгийн орлогоор 2007 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр **9.0** тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 2007 онд хүүгийн орлогын төлөвлөгөөг 8.4 хувиар буюу 700.0 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 2006 оныхоос 2 дахин нэмэгдүүлсэн явдал чамлахааргүй амжилт боллоо.

Засгийн газар байгуулагдсанаас хойшхи хугацаанд Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Хот байгуулалтын салбарын төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай, Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн нийгэмлэг хооронд байгуулсан “Тогтвортой амьжиргаа-2” төслийн Санхүүжилтийн гэрээний тухай, Монгол Улсын Засгийн газар болон Мянганы сорилтын сангаар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй АНУ-ын Засгийн газар хоорондын Мянганы сорилтын гэрээг соёрхон батлах тухай хуулийг УИХ-аар батлууллаа. Эдгээрийг баталснаар манай улс 2008 оноос 359.2 сая ам.долларын зээл, тусламжийг ашиглах бололцоотой болсон байна.

Монгол Улсын Засгийн газар, Гадаадын түнш нарын хамтарсан Техникийн 4 дэх удаагийн уулзалтыг “Хувийн хэвшлийг хөгжүүлэх стратеги” сэдвээр (2008 оны 1 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд) амжилттай зохион байгууллаа. Энэхүү дөрөв дэх удаагийн уулзалтад УИХ-ын ба Засгийн газрын гишүүд, яам, агентлаг, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, бизнесийн холбоо, гадаадын түнш байгууллагуудын 200 гаруй төлөөлөгч оролцсон байна. Засгийн газраас санаачлан боловсруулсан Хувийн хэвшлийг хөгжүүлэх стратегийн баримт бичгийн талаархи нээлттэй хэлэлцүүлгийг уулзалтад оролцсон төлөөлөгчид сайшаан хүлээн авлаа.

**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулах, улмаар худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн шинэ орчныг зүгшрүүлэх талаар идэвхитэй ажиллаж байна.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр 10 орчим заавар, журам, тендерийн баримт бичгийг батлуулан мөрдүүлэх арга хэмжээ авлаа. Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудасны агуулга, бүтцийг ([www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn)) сайжруулах, шинэчлэх ажлын хүрээнд нэлээд ажлыг зохион байгуулсан байна. Тухайлбал, Худалдан авах ажиллагааны цахим хуудсанд захиалагч байгууллагууд вэб сайтад тавигдах зарыг хүлээж авах өдрийг 30 буюу түүнээс дээш автоматаар сонгогдож байхаар, цахим хуудсанд шинээр нийтлэгдсэн эрхийн акт болон мэдээллийн ард “шинэ” гэсэн өргөтгөл эхний 10 хоногийн дотор гарч байхаар тохируулсан байна.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд нийт 52 төсвийн ерөнхийлөн захирагч 2008 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө ирүүлэхээс 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар худалдан авах ажиллагааны 2008 оны ерөнхий төлөвлөгөөг 48 байгууллага ирүүлснийг худалдан авах ажиллагааны цахим хуудас ([www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn))-нд нийтэлсэн байна.

**Засгийн газрын санхүүгийн мэдээллийн нэгдсэн сүлжээний техникийн боломжит хүч чадлыг ашиглан санхүүгийн шинэ нэр төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх ажилд нааштай ахиц гарч байна.** Санхүүгийн мэдээллийн нэгдсэн сүлжээний ажлын ачаалал өссөнтэй уялдуулан Засгийн газрын 2008 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 26 дугаар тогтоолоор мэдээллийн нэгдсэн сүлжээний ашиглалтын талаар зарим арга хэмжээ авсан байна. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн ажиллагааг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн урсгал төсөвт нэгдсэн журмаар тусган санхүүжүүлж, Засгийн газрын санхүүгийн удирдлагын

мэдээллийн нэгдсэн сүлжээний ашиглалтын заавар, журмыг 2008 оны 1 дүгээр улиралд багтаан баталж мөрдүүлэх арга хэмжээ авах үүргийг Сангийн сайдад өгөв.

### **Үйлдвэр, худалдааны салбарт**

**Эрдэс баялгийн салбарт эрх зүйн орчинг боловсронгуй болгож байна.** “Ашигт малтмалын тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, хөрөнгө оруулалтын гэрээний хугацааг 15 жилээр байгуулах, гэрээний хугацааг харилцан тохиролцсоны үндсэн дээр сунгаж болох, стратегийн ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг компанийн дүрмийн сангийн 51.0 хувиас дээш байхаар уг хуулийн төсөлд тусгалаа.

“Алт” хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн саналыг үндэслэн “Шинэ Алт” хөтөлбөрийг боловсруулахаар шийдвэрлэв.

Геологийн төв лабораторийн үйл ажиллагааг бэхжүүлж, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 200.0 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийлээ.

**Гар аргаар ашигт малтмал олборлогчдын асуудалд төрөөс зохицуулалт хийж, жижиг, дунд үйлдвэрлэлийн хэлбэрт шилжүүлэхээр боллоо.** Орон нутагт үйлдвэрлэлийн аргаар ашиглагдаж байгаад орхигдсон алтны үндсэн ордын хаягдал, хувиараа ашигт малтмал олборлогчдын олборлож байгаа хүдрийг нэг цэгт төвлөрүүлэн байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хор нөлөөгүй, хаягдалгүй технологиор үйлдвэрлэл эрхлэх нөхцлийг бүрдүүлэх замаар алтны үндсэн ордод хүдэр баяжуулах жижиг, дунд үйлдвэр байгуулах загварыг боловсруулав. Түүнчлэн, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа асуудлыг зохицуулах түр журам болон дэд хөтөлбөрийг баталж, гадаадын холбогдох байгууллагын туслалцаатайгаар олон нийтийн санаачлагад тулгуурлан уг ажлуудыг эхлүүлж байна.

**Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн орд газруудыг төр мэдэлдээ авч эхэллээ. Түүнчлэн ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх хүрээнд тодорхой ажлуудыг эхлүүлэв.** Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн орд газрууд болох Шивээ овоо, Төмөртэйн орд газрын тусгай зөвшөөрлийг төрийн өмчит “Эрдэнэс МГЛ” компанид шилжүүлэв.

УИХ-аас баталсан стратегийн орд газруудын хил хязгаарыг нарийвчлан тогтоож, Төрийн өмчийн хороо болон холбогдох газруудын хяналтад шилжүүллээ.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг цахим хэлбэрт оруулж, ил тод, нээлттэй, нийтэд хүртээлтэй болгох зорилго бүхий төслийг Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж эхлээд байна.

Тусгай зөвшөөрөл олгох шилжүүлэхтэй холбогдон гардаг зөрчил, дутагдлыг арилгах, цаашид байнгын хяналттай болгох үүднээс АМГТХЭГ-ын Кадастрын албанд төрийн бус болон олон нийтийн байгууллагуудын төлөөлөлтэй хамтран шалгалт хийж байна.

**Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжин хөгжүүлэх хүрээнд төр, хувийн хэвшил хамтын ажиллагаа, түншлэлийг хангахад анхаарч байна.** Монгол Улсын Засгийн газар, Гадаад түншүүдийн Техникийн 4 дэхь удаагийн

уулзалтад төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны болон олон улсын байгууллагуудын нийт 150 орчим төлөөлөгчид оролцов. Уулзалтын үр дүнд дэвшилтэт техник технологи, мэргэшсэн, ур чадвартай ажиллах хүчин, өөрийн орны түүхий эд, эрдэс баялагийн нөөцөд тулгуурласан, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий, байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх алсын хараа бүхий Хувийн хэвшлийн хөгжлийн стратегийн баримт бичгийг боловсруулав.

**Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлд ахиц гаргалаа.** Испани улсын Зарагоза хотод 2008 оны 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэлх хугацаанд зохион байгуулагдах “Ус ба тогтвортой хөгжил” сэдэвт олон улсын үзэсгэлэнд оролцох болов.

Монгол Улс, АНУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд АНУ-ын Хөнгөлөлтийн ерөнхий системд Монголын гар урлалын зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг хамруулахаар харилцан тохиролцов.

Монгол, Оросын бизнес форумыг 2007 оны 12 сарын 7-8-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Хоёр талын 100 гаруй компанийн 364 төлөөлөгч оролцсон тус форумас Монгол Улсын уул уурхай, зам тээвэр, эрчим хүчний салбарт харилцан ашигтай хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх, хоёр талын худалдаанд учирч буй тарифын болон тарифын бус саадыг арилгах, бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилтыг дэвшүүлж, хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурсан. Эхний ээлжинд ОХУ-аас Монгол Улсад гурил, улаанбуудайг хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлэх талаар харилцан тохиролцлоо.

Канадын Олон улсын худалдааны сайд Дэвид Эмерсон 2008 оны 1 сарын 9-10-ны өдрүүдэд Монгол Улсын Үйлдвэр, худалдааны сайдын урилгаар айлчлав.

**Иргэд “Нэг цэгийн үйлчилгээ”-г таашааж байна.** Төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх, ил тод болгох, хүнд суртлыг багасгах зорилгоор 2007 онд Засгийн газар “Нэг цэгийн үйлчилгээ”-г бий болгох, тус үйлчилгээг улс орон даяар нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг батлав. “Нэг цэгийн үйлчилгээ”-г нийслэлийн Сухбаатар дүүрэгт жишиг байдлаар байгуулж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авах, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, халамж, даатгал, татвар, хураамж, банк, нотариат, мэдээлэл, зөвлөлгөө өгөх зэрэг үйлчилгээг нэг дороос чирэгдэлгүй үзүүлж байна. Цаашид үйлчилгээний төрлийг өргөжүүлж, цахим хэлбэрт оруулахаар төлөвлөсөн ба ойрын 3 жилд багтаан нийслэлийн бүх дүүрэг, түүнчлэн аймгийн төвүүдэд тус үйлчилгээний төвийг байгуулна.

**Нефть, нефтийн бүтээгдэхүүний хангамжыг сайжруулж, үнийг тогтворжуулах талаар тодорхой ажлууд хийлээ.** Газрын тосны бүтээгдэхүүний үнийг тодорхой хугацаанд тогтвортой түвшинд байлгах талаар дотоодын импортлогч компаниудтай хамтран ажиллаж ирлээ.

**Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд төрөөс бодитой дэмжлэг үзүүлж эхэллээ.** Нийслэлийн хүн ам олноор суурьшсан Сонгинохайрхан дүүрэгт сургалт, зөвлөгөө, мэдээллээр хангах, мөн түүнчлэн инкубаторын үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий “ЖДҮ-ийг дэмжих төв”-ийг нээн ажиллуулж байна. Энэхүү төвд шинээр байгуулагдаж буй аж ахуйн нэгж байгууллагууд болон

хувиараа бизнес эрхлэгчид хөнгөлөлттэй зээл олж авах талаар зөвлөгөө авах, бизнес сургалтад хамрагдах зэрэг төрөл бүрийн бизнес үйлчилгээг цаг тухайд нь авах боломжоор хангагдаж байна.

Хөдөө орон нутгийн ЖДҮ-ийг санхүү, зээлийн бодлогоор дэмжих ажлын хүрээнд улсын төсөв, нийслэл, аймаг орон нутгийн төсөв, мөн арилжааны банк зэргээс нийт 239 төсөлд 2.7 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Үүнээс, 15 аймагт 713.6 сая төгрөгийн зээл, Улаанбаатарт 1964.9 сая төгрөгийн зээл тус тус олгожээ.

**Хөнгөн аж үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг батлууллаа.** Экспортын гол бараа бүтээгдэхүүний нэг болох ноос ноолуурын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх зорилтын хүрээнд “Ноолуур-2012 он хүртэл авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан батлав. Тус төлөвлөгөө хэрэгжсэнээр нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болох юм.

Сүүлийн жилүүдэд хэвлэмэл бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээ эрчимтэй өсөж байгаатай холбогдуулан үндэсний хэвлэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг харгалзан хэвлэлийн үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцлийг бүрдүүлж үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг олон улсын жишигт хүргэх зорилго бүхий “Хэвлэлийн үйлдвэрлэл” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх ажилд ороод байна.

Дөрөв. ХОТ БАЙГУУЛАЛТ, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН  
БОДЛОГЫН ТАЛААР

### **Барилга, хот байгуулалтын салбарт**

*Барилга, орон сууц нийтийн аж ахуй*

Тус салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр “Барилгын тухай” хуулийг УИХ-аар батлуулж, түүнийг хэрэгжүүлэхтэй уялдсан 10 гаруй дүрэм, журмыг боловсруулан мөрдүүлэх ажлыг хийж байна. Ингэснээр барилгын үйл ажиллагаа эрхлэх байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл олгох, барилгын ажлыг эхлүүлэх зэрэг олон шат дамжлагыг цөөлж нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлж, хариуцлагыг өндөржүүлэх юм.

“Хүн амыг орон сууцаар хангах, барилгын салбарт ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг УИХ-д өргөн барьлаа. Орон сууц барих ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулагчдад хөнгөлөлт үзүүлэх, орон нутгийн эрдэс түүхий эдэд тулгуурласан барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг сааруулах зорилгоор “Барилгын материалын зарим үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгэж байна.

Барилгын ажилчдын тарифт цалинг нэмэгдүүлж, дундаж цалингийн хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 50-60 хувиар нэмэгдүүлэх тооцоо гарган ажиллаж байна. Үүний үр дүнд салбарын хэмжээнд үндэсний

барилгачдын эзлэх хувийг нэмэгдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх болно.

“40 000 орон сууц” хөтөлбөрийг санхүүжүүлэх журам “-ыг баталж хөтөлбөрийн санхүүжилтийг саатуулахгүй байх арга хэмжээ авч орон нутагт баригдаж буй орон сууцны барилгад 4,2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийлээ. Засгийн газрын бондын хөрөнгийн эх үүсвэрээр орон сууцны урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох ажлыг эхлүүлж, 150 гаруй иргэдийн хүсэлтийг хүлээн авлаа. Ойрын үед арилжааны 5 банкаар дамжуулж зээл олгоно.

“Хот, суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” “Орон сууцны тухай” хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

“Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах 2 дахь шатны хөтөлбөр”, “Сум, суурин газрын дулаан хангамжийн шинэчилсэн хөтөлбөр” боловсруулав. Эдгээр хөтөлбөр нь нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын бүтэц зохион байгуулалтыг зах зээлийн нөхцөл шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох сум суурингийн дулаан хангамжийг сайжруулахад чиглэгдэж байна. “Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд “Төрийн албан хаагчдад хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг боловсруулаад байна. Энэхүү 100 хоногт 45 барилга, түүний дотор 1143 айлын орон сууцны 23 барилгыг улсын комисс хүлээн авч байнгын ашиглалтад орууллаа.

#### *Хот байгуулалт*

Төрөөс хот байгуулалтын талаар баримтлах бодлогын төслийг боловсруулж, холбогдох газруудын саналыг авч байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг багасгах, гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхлэв. Нийслэлийн 20 орчим гэр хороололд дахин төлөвлөлт хийгээд байна. Тухайлбал, эхний ээлжинд “14, 7, радио телевизийн орчны хороолол”, дараагийн ээлжинд “Зүүн сэлбэ, Гандан, Дарь эх, дэнжийн 1000, 7 дугаар бичил хорооллыг хамруулах болов.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийслэлд оюутны хотхон байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулж, Буянт-Ухаад 60 га газрыг олгуулах шийдвэр гаргав. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2008 оны төсөвт тусгаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн хороог байгуулаад байна.

“Цагаан нуур”, “Замын-Үүдийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Говийн бүсийн Таван толгой, Оюу толгой, Цагаан суврагын орд газрыг түшиглэсэн бүсий хөгжлийн стратеги, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусгав. Мөн Улиастай хотын төвийн хэсгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулав.

#### *Газрын харилцаа, эрхийн бүртгэл*

“Геодези, зураг зүйн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барив. “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн

дуудлага худалдаа явуулах журам”, “Газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулах журам”, “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох, бусдад шилжүүлэх гэрчилгээний хугацааг сунгуулахад төлөх хураамжийн хэмжээг тогтоох тухай” журмын төслүүдийг боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахаар бэлтгэж байна. Эдгээр журам батлагдсанаар газрын харилцааны үйл ажиллагаа нээлттэй ил тод явагдах, эзэмшил, ашиглалтад байгаа газарт зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн төлбөр, хураамжийг бодитой тогтоох нөхцөл бүрдэх юм.

“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай”, “ Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулан иргэд, гэр бүлийн хэрэгцээнд үнэгүй газар өмчлүүлэх хугацааг 5 жилээр сунгах заалтыг тусган УИХ-д өргөн барихаар боллоо.

“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай” хууль болон “Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааны тухай” хуулиудад өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулав.

Засгийн газар 100 хоногийн хугацаанд улсын хэмжээгээр 14990 өрх, гэр бүл 1630,3 га газрыг өмчилж, 143 иргэн 1629,5 га газрыг аж ахуйн зориулалтаар худалдан авсан байна.

### **Зам тээвэр, аялал жуулчлалын салбарт**

#### *Авто зам*

Авто замын салбарт 2008 онд улсын төсөв, “Монгол Улсыг хөгжүүлэх” сангаас **83.6** тэрбум төгрөг, гадаадын зээл, тусламжаар **60.4** орчим тэрбум төгрөг, нийтдээ **144.0** гаруй тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж 500 км хатуу хучилттай зам барих зорилт тавьж байна.

2008 онд улсын чанартай авто замыг засварлах, арчлах, хамгаалах, сайжруулах замын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэхэд авто замын сангийн хөрөнгөөс 9.0 тэрбум төгрөгийн санхүүжүүлэлт хийх болсон нь 2007 оныхоос 2.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэв.

Энэ хөрөнгөөр замын засвар, арчлалтыг хийхийн зэрэгцээ төрийн өмчит засвар арчлалтын байгууллагуудын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, тоног төхөөрөмж, машин механизмыг шинэчлэх болон улсын чанартай авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс өндөр далан, огцом эргэлттэй хэсгүүдэд төмөр туузан хашлага суурилуулах, тэмдэгжүүлэхэд зориулахаар төлөвлөж тендер зарлаад байна. Мөн Кувейтийн сангийн хөрөнгөөр төрийн өмчит засвар, арчлалтын байгууллагуудыг тоног төхөөрөмж, машин механизмаар хангахаар тендер зарлан дүгнээд байна.

“Монгол Улсын 2008 оны төсвийн тухай” хуульд тусгагдсан авто замын салбарын төсөл, арга хэмжээг эрт эхлүүлэх, бэлтгэл ажлыг нь хангуулах зорилгоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай” хуулийн дагуу энэ онд зарлагдах нийт тендерийн 60.0 хувийг зарлаад байна. Ингэснээр 2008 онд авто замын салбарын хөрөнгө оруулалтын арга хэмжээг цаг хугацаанд нь эхлүүлэх бололцоотой болж байна.

Улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар 2008 онд шинээр баригдах Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 27км, Улаангом-Тээлийн гүүр чиглэлийн 15км, Баянхонгор-Нарийнтээлийн 50км, Өндөрхаан-

Сүмбэрийн 50км, Мөрөн-Хатгалын 98.8км хатуу хучилттай авто зам, Хөвсгөл аймагт Сэлэнгэ мөрөн дээр Цацын булангийн 253.3у/м, Идэрийн голын 163.1у/м, Архангайд Хануйн голын 127у/м, Завхан аймгийн Их-Уул суманд Идэрийн голын 169.9у/м, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт Ховдын голын 127.09у/м, Сагсай сумын Турганы голын 96.95у/м, Улаанхус сумын Ховд голын 163.1у/м гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан дүгнэж байна.

2008 онд Улсын төсөв болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр орон нутагт 8340.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөнөөс нийт 19 аймаг, нийслэлд 8277.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэх гэрээг орон нутаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулаад байна.

Монгол Улсын авто замын сүлжээг хөгжүүлэхэд хувийн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор Мандалговь-Даланзадгадын чиглэлийн 163 км, Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 107 км, Баянхонгор-Алтайн чиглэлийн 128 км, Тосонцэнгэл-Улаангом чиглэлийн 197 км, Баруун-Урт-Эрдэнэцагаан-Бичигтийн чиглэлийн 290 км хатуу хучилттай авто зам зэрэг 14 объектыг эргэн төлөгдөх нөхцөлөөр бариулахаар Засгийн газрын шийдвэр гаргаад байна.

#### *Төмөр зам*

“Ойрын болон дунд хугацаанд шинээр төмөр замын сүлжээ байгуулах хэтийн төлөвийн тухай” асуудал болон “Төмөр замын хоёр дахь шугам барих техник-эдийн засгийн үндэслэлийн судалгаа”-г хийж дуусган Засгийн газрын хуралдаанд оруулахаар бэлтгэж байна.

2007 онд Замын-Үүд өртөөний ачаа тээвэрлэлтийн хэмжээ эрс нэмэгдсэнтэй холбогдуулан тээвэрлэлтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн түрээсээр 2 илчит тэрэг авсны зэрэгцээ ачааны вагоны паркийг 350, зорчигчийн вагоны паркийг 16 вагоноор тус тус нэмэгдүүллээ.

“Монгол Улсын 2008 оны төсвийн тухай” хуулиар батлагдсан 15,0 тэрбум төгрөгөөр 3 илчит тэрэг, 150 вагон худалдан авах асуудлыг шийдвэрлээд байна.

#### *Иргэний нисэх*

Хөрш хоёр улсын иргэний нисэхийн байгууллагуудтай хамтран ажиллаж, одоо ашиглагдаж байгаа “INTIK” агаарын хаалганы зэргэлдээ шинэ агаарын хаалга нээж ашиглах, Мөрөн, Эрхүүгийн хооронд шууд нислэг хийх агаарын зам, хаалгыг 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн нээх, мөн 2008 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Улаанбаатар-Бээжингийн чиглэлд нислэгийн давтамжийг долоо хоногт найм байсныг 14 болгон нэмэгдүүлэх асуудлыг тус тус тохиролцлоо.

Олон улсын нислэгийн тоо, зорчигч тээвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор 2008 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс 189 зорчигчийн суудалтай B737-800W маягийн агаарын хөлгийг үйл ажиллагааны түрээсээр авч ашиглахаар Сингапур Улсын "CIT Capital Aviation (UK) Limited" компанитай “МИАТ” ХК компани гэрээ байгууллаа. Ингэснээр үндэсний тээвэрлэгч “МИАТ” ХК нь урьд онуудтай харьцуулахад олон улсын чиглэлд 30 гаруй хувь илүү зорчигч тээвэрлэх техникийн нөхцөл бүрдэх юм.

Олон улсын шинэ нисэх буудал байгуулах төслийн эцсийн судалгааг дуусгасан бөгөөд Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банкны зүгээс

зээлийн хэлэлцээрийн төслийг боловсруулж байна. Уг төслийг ойролцоогоор 290.0 сая ам.долларын санхүүжилтээр 2014 он гэхэд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн болно.

### *Аялал жуулчлал*

“Шинэ оны нар харах” аялалыг 2008 оны 1 дүгээр сарын 01-нд “УБТЗ”-ын Аялал жуулчлалын товчоотой хамтран зохион байгууллаа. Түүнчлэн Хөвсгөл нуур дээр өвлийн аялал, аялал жуулчлалын уламжлалт “Мөсний баяр”, Өмнөговь аймагт “Тэмээний баяр”, Баян-Өлгий аймагт “Бүргэдчидийн баяр” зэрэг арга хэмжээг зохион байгуулав.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлэх зорилгоор хамтарсан ажлын хэсэг байгуулан хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хийгдэх Аялал жуулчлал эрхлэгчдийн үндэсний чуулганы бэлтгэлийг хангаж байна.

“Аялал жуулчлалын бүс нутаг тогтоох”, “Хөвсгөл-Байгаль нуурын бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр” зэрэг бодлогын асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгэж байна.

### *Шуудангийн үйлчилгээ*

Шуудангийн зип кодыг улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Вэб хуудас, лавлах номыг гарган яам, агентлагууд болон шуудангийн компаниудад зориулсан сургалт, семинарыг зохион байгуулав. Уг кодыг нэвтрүүлснээр хаягаар хүргэдэг аливаа үйлчилгээг дэлхийн улс орны хэрэглэгчдийн нэгэн адил өөрийн тогтвортой хаяг, байршлаар хүлээн авах боломжтой боллоо.

“Монголшуудан” ХХК-ийн өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, санхүүгийн хүндрэлийг арилгах арга хэмжээ авсны дээр, шуудангийн үндсэн сүлжээний техник хангамжийг сайжруулахад шаардлагатай шуудан хүргэлтийн автомашин, мотоцикль худалдан авах, мэдээллийн сүлжээ байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтын талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн 2008-2009 онд улсын төсвөөс санхүүжүүлэх шийдвэр гаргав.

### **Түлш, эрчим хүчний салбарт**

Улс орны хэмжээнд өсөн нэмэгдэж байгаа түлш, эрчим хүчний хэрэгцээг хангах, эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэх, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, ойрын, дунд болон урт хугацааны зорилт, хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойлон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, “Агаарын бохирдлыг бууруулах талаар ойрын хугацаанд авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоол гаргав. Нүүрсийг дулааны аргаар боловсруулах ажлыг эрчимжүүлж, Улаанбаатар

хотын гэр хорооллын хэрэгцээнд болон халаалтын зууханд түлш нийлүүлэх ажлыг зохион байгуулах, стандартын шаардлага хангасан, чанарын өндөр үзүүлэлттэй коксон түлшний үйлдвэрлэлийг төрөөс хөхиүлэн дэмжих, эдийн засаг, татварын хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх, коксон түлшийг хэрэглэгчдэд хүргэх, түгээх зорилгоор борлуулалтын сүлжээ цэг байгуулахаар ажиллаж, 2009 оноос эхлэн хотын гэр хорооллын хэрэглэгчдийг хангах зорилт тавьж байна.

Монгол-Хятадын нүүрс, эрчим хүчний хамтын ажиллагааны Төслийн ажлын хэсгийн 5 дахь хуралдааныг Улаанбаатарт зохион байгуулж, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн барих дулааны цахилгаан станц болон уурхай барих төслийн бэлтгэл ажил, нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэлийг хийж дуусгах, цогцолборын барилгын ажил эхлүүлэх, төслийн хөрөнгө оруулалтын хэлбэр, цахилгаан станц, дамжуулах сүлжээ, уурхайн эзэмшлийн хувь хэмжээ, цахилгаан худалдах үнэ зэрэг хамтын ажиллагааны зарчмын асуудлууд, дулааны цахилгаан станцын усны хангамж, цахилгаан станц болон тогтмол гүйдлийн дамжуулах шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэж, харилцан ойлголцлолын баримт бичигт гарын үсэг зураад байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн дагуу 2008 оны улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар баригдах эрчим хүчний барилга байгууламжийн гүйцэтгэгчийг сонгох тендерийн үнэлгээний хороодыг байгуулж, 22 объектын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийг зарласан. Одоогоор 13 объектын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж эхлээд байна. 127 сумын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэх ажлыг эхлүүлээд байна.

Улаанбаатар хотын эрчим хүчний 5 дахь эх үүсвэрийг хотын зүүн хэсэгт барихаар төлөвлөж, зураг төсөл, барилгын ажлын тендерийн баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийг томилж, уг ажлыг эхлүүлээд байна. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж, төслийн үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар холбогдох шийдвэрүүдийг гаргаж, Дөргөн, Тайширын Усан цахилгаан станцын эхний ээлжийг 2008 оны 6 дугаар сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулаан-механикийн тоноглолын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм, Дулааны цахилгаан станцын тоног төхөөрөмжийн засварын ажлын хөдөлмөр зарцуулалтын норм, салбарын үйлдвэр, компаниудын аюулгүй, найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай түлш болон тоног төхөөрөмж, сэлбэгийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх журам, Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд эрчим хүчний хангамжийн талаар мөрдөх журмыг шинэчлэн боловсруулж салбарын хэмжээнд мөрдүүлж байна.

Шивээ-Овоогийн нүүрсний орд газрын тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэв.

Эгийн голын Усан цахилгаан станцыг барих талаар Хятадын талтай хийж байгаа хэлэлцээний нөхцөл нь Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан 300.0 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн ашиглалтын талаархи Зээлийн ерөнхий хэлэлцээртэй зөрчилдөж хүлээж авах боломжгүй байгаа тул Эгийн голын усан цахилгаан станцын төслийг уг зээлээр хэрэгжүүлэх ажлыг зогсоох талаар Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж, зөвшилцөхөөр тогтоод байна.

### **Хүнс, хөдөө аж ахуйн салбарт**

Импортолсон хүнсний буудай болон 40.0 мянган тонн буудайн гурилын гааль, нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээг “0” байхаар тогтоолгож, **гурилын хангамжийг нэмэгдүүлэн, дотоодын зах зээл дээрх үнийг харьцангуй бууруулан тогтворжуулах арга хэмжээ авав.** Мөн гурил, улаан буудайн стратегийн нөөц бүрдүүлэх асуудлыг УИХ-аар шийдвэрлүүлэв. Гурилын хэрэгцээ, хангамжийг тогтворжуулах зорилгоор дотоодын 8 мян.тн, БНХАУ-ын тусламжийн 2.0 мян.тн улаан буудайг “Алтан тариа”, “Улаанбаатар гурил” ХХК-иудад олгон гурилын үнийг тогтворжуулах гэрээ байгуулан ажиллав. ОХУ-аас хөнгөлөлттэй нөхцөлөөр гурил, улаан буудай авах тухай асуудлыг Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын дарга нарын түвшинд ярилцаж, тохиролцон Протокол байгуулав.

Дээрх протоколын дагуу ОХУ-аас импортлох 200.0 мян.тн улаан буудайн эхний ээлжийн 85.0 мян.тн улаан буудайг хөнгөлөлттэй үнээр импортлох гэрээ байгуулагдаад байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх цогц арга хэмжээг тусгасан **“Атрын 3 дугаар аян” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэхээр шийдвэрлүүлэв.**

Стратегийн хүнсний таримал болох улаан буудайн тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2007 оны ургацаас гурилын үйлдвэрүүдэд нийлүүлсэн буудайн тонн тутамд төрөөс 60.0 мянган төгрөгийн урамшуулал олгох шийдвэр гаргуулсны дагуу нийт 11 аймгийн 217 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 65887 тонн буудайнд 3,953,227.8 мянган төгрөгийн урамшуулал олгох ажлыг зохион байгуулав.

2008 оны хаврын тариалалтад 24.9 мянган тонн үр шаардагдахаас тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэд 15.5 мянган тонн үр нөөцөлсөн бөгөөд үүн дээр Улсын нөөцийн урьд оны үлдэгдэл 3.0 мянган тонныг нэмж тооцвол 18.5 мянган тонн үрийн буудайн нөөц бүрдэж, 6.4 мянган тонн үр дутагдах тооцоо гарсны дагуу “Үрийн улаан буудай худалдан авах” тендерийн баримт бичгийг боловсруулан, тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.

2008 оныг **“Хүнсний хангамж аюулгүй байдлын жил”** болгон зарлаж, энэ ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлэв.

Нийслэлд 7000 тн, Дархан, Эрдэнэт хотуудад тус бүр 500 тн махыг хүн амын 2008 оны хаврын хэрэгцээнд зориулан бэлтгэж, нөөцлөх ажлыг зохион байгуулав. Нийслэлийн хүн амын хавар, зуны улирлын махны нөөцийг “Махмаркет”, “Монгол махэкспо”, “Махэкспорт”, “Дорнын говь”, “Тайж трейд” зэрэг нийт 10 аж ахуйн нэгж бэлтгэж нөөцлөн, тогтоосон үнээр 150 орчим худалдааны цэгээр хуваарийн дагуу борлуулах үүрэг хүлээн гэрээ байгуулаад байна. Эдгээр аж ахуйн нэгжид гэрээт 7000 тн махнаас гадна адуу, ямааны 2726.3 тн тураг мах, шулсан мах болон дотор, дайвар бүтээгдэхүүн хадгалагдаж байна. Махны хадгалалт, нөөц бүрдүүлэлтийн байдалд 4 удаа нэгдсэн шалгалт хийж, шаардлагатай зохицуулалтыг хийн ажиллаж байна.

Дархан-Уул аймагт 350 тн, Орхон аймагт 300 тн мах бэлтгэж нөөцлөхөөр гэрээ хийгдэж нөөцөлсөн махыг үйлдвэрээс 2000 төгрөг, дэлгүүрт 2100 төгрөгөөр борлуулахаар шийдвэрлэсэн. Цаашид орон нутгийн нөөц бололцоог дайчлан нөөцлөх махны хэмжээг 500 тн болгож нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг дээрх аймгуудын удирдлагад үүрэг болгоод байна.

“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, Улсын тэргүүний тариаланч”-аар шалгаруулах малчин, тариаланч, тариаланч хамт олны тоог нэмэгдүүлэн “Улсын сайн малчин”-аар 21 аймгийн 40 хүнийг, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-оор 8 аж ахуйн нэгж, “Улсын тэргүүний тариаланч”-аар 15 хүнийг тус тус шалгаруулж Засгийн газрын шагналыг сар шинийн баярын өмнө гардуулав.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөлгөөн, семинарыг анх удаа орон нутагт буюу Булган аймгийн төвд зохион байгуулж, зөвлөлгөөнд 21 аймаг, нийслэлийн холбогдох агентлаг, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөгч нийт 150 хүн оролцов. Зөвлөлгөөнөөр “Салбарын 2008 оны тэргүүлэх зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга замын тухай” асуудал хэлэлцүүлж, зорилтоо тодорхойлов.

Мал өвөлжилтийн бэлтгэл хангасан дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, мал өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалтай холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол гарган хэрэгжилтийг зохион байгуулж байна. Тухайлбал, Засгийн газрын тогтоолоор малаа оторлож яваа малчдад төрийн үйлчилгээ үзүүлэх, өвс тэжээл тээвэрлэн хүргэхэд зориулан 9 аймагт 210.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэв.

Адууны томуугаас сэргийлэх вакцин 4130 литр буюу 826000 тунг захиалан үйлдвэрлүүлж хөдөө орон нутагт хүргүүлэн адууг вакцинжуулах арга хэмжээ авав. 2008 оны 2 дугаар сарын 25-ны байдлаар вакцинжуулалт 75.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн томуугийн үед эмчилгээний зорилгоор хэрэглэх 36000 флакон “Тилозин-200” антибиотیکیг нийлүүлэх арга хэмжээг тендер зарлан зохион байгуулж, уг бэлдмэлийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн албадад хүргүүлэв. Бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хэрэглэх 560.0 сая төгрөгийн үнэ бүхий 12 нэрийн вакциныг захиалгын дагуу үйлдвэрлүүлэн орон нутагт хүргэх ажлыг зохион байгуулав.

БНСУ-ын Засгийн газрын санхүүжилтээр Солонгосын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн (KOICA) шугамаар төсөл хэрэгжүүлж, мал, амьтанд халдварлах өвчнийг оношлох **биоаюулгүй байдлын 3 дугаар**

**зэрэглэлийн (BSL–III) лабораторийг шинээр байгуулж, ашиглалтад оруулав.** Ингэснээр мал, амьтны гоц халдварт болон хүнд дамжин халдварлаж болзошгүй аюулт халдварт өвчний үүсгэгчийг цэврээр ялган авч оношийг тодруулах, баталгаажуулах, дээрх зорилгоор эмгэгт материалтай ажиллах лабораторийн өндөр хүчин чадавх бүхий аюулгүй орчин бүрдэж байгаа юм.

Хөдөө аж ахуйн салбарт 2008 онд ашиглах ургамал хамгааллын бодис, гербицид, химийн бордоо, мал эмнэлгийн зориулалттай пестицидийн жагсаалтыг Байгаль орчин, Хүнс, хөдөө аж ахуй, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлав.

“Цаа бугын удмын санг хамгаалах, цаачин иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг СЯ, БОЯ, БСШУЯ, ТЭХЯ, ЭМЯ хамтран зохион байгуулж байна.

Мал тооллогын дүнг Үндэсний статистикийн хороотой хамтран гаргаж, 2007 оны эцсийн дүнгээр **мал сүрэг 5 төрөл дээрээ өсөж 40.2 саяд хүрэв.**

### **Харилцаа холбооны салбарт**

Монгол Улсын сум, суурин газрын мэдээлэл, холбооны дамжуулах байгууламжийн судалгааг хөдөлгөөнт холбооны үйлчилгээ эрхлэгч компаниудын үйлчилгээ хүрсэн, шилэн кабелийн сүлжээ, сансрын холбооны ВиСат системд холбогдсон сум, суурин газруудын талаарх мэдээллийг хамруулан 2007 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн гаргалаа.

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч компаниуд хоорондоо E1 түрээсийн сувгаар холбогдож буй байдлыг интернэт протоколд /IP based/ суурилсан холболтод шилжүүлэх асуудлыг судалж хэрэгжүүлэх зорилгоор холбогдох талуудыг оролцуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

“Шилдэг програм хангамж-2007” уралдааныг анх удаа зохион байгуулж, шилдэг програм хангамжийн бүтээгдэхүүн, шилдэг програм ашиглагч байгууллага гэсэн 2 ангиллаар явуулав. Уралдаанд нийт 20 гаруй бүтээл ирснээс шилдэг програм хангамжийн бүтээгдэхүүнээр Интер актив компанийн санхүү, бүртгэлийн “Интерактив даймонд” програм, шилдэг програм ашиглагч байгууллагаар Гаалийн ерөнхий газар “Гаалийн мэдээллийн ГАМАС” системээрээ тус тус шалгарлаа.

**Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох үндэсний хөтөлбөрийг** боловсруулан баталж, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай Үндэсний хороог байгуулан ажиллаж байна. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд гүйцэтгэх 6 цогц арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх ажлыг эхлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын “Хувийн хэвшлийн хөгжлийн стратеги” баримт бичгийн төсөлд оруулах саналыг “Цахим Монгол” үндэсний хөтөлбөртэй уялдуулан боловсруулав. Засгийн газрын мэдээллийн нэгдсэн төв байгуулах төслийн хөрөнгө оруулалтын задаргаа болон төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж байна.

Мөн Монгол Улсад “Компьютерийн халдлагад хариу өгөх тогтолцоо”-г бий болгох тухай төсөл боловсруулж тендерийн материалыг боловсруулж дуусгав.

Мэдээллийн технологийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор олон улсын СММІ стандартыг Монголд нэвтрүүлэх тухай төслийн санал боловсруулж, шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх асуудлыг донор байгууллагад хүргүүлэв.

Монгол Улсад Микрософтын албан ёсны төлөөлөгчийн газрыг нээх, тус компанийн үндсэн програм хангамжуудыг Монгол хэл рүү хөрвүүлэх, цахим засаглал, цахим боловсрол болон зохиогчийн эрхийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцоод байна.

“Мэдээллийн технологийн танин мэдэхүйн төв”-ийн нэг хэсэг болох “Цахим засаглал”-ын бүрдэлд цахим иргэний бүртгэлийн систем, цахим эрүүл мэнд, цахим сонгуулийн вэб хуудсуудыг боловсруулж дуусгалаа.

“Төрийн байгууллагуудын вэб, и-мэйл” төслийн хүрээнд хийсэн “Жуумла Монгол” системийн тусламжтай боловсруулсан “Төрийн байгууллагуудын нэгдсэн портал”-ыг ашиглаж эхлэв.

## Тав. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ТАЛААР

**Байгаль орчны хобогдолтой хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулан эрх зүйн шинэчлэлт хийж байна.** Тухайлбал, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Химийн хорт ба аюултай бодисын тухай” хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиудыг УИХ-ын 2008 оны 1 дүгээр сарын нэгдсэн чуулганаар батлуулсан нь байгаль орчны мэдээллийн сан, технологийн иж бүрдэл, бүртгэл, мэдээллийн ил тод, нээлттэй, байдал хангагдаж, химийн бодисын зөвшөөрлийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналтадаа авах эрх зүйн орчин бүрдлээ.

Байгаль орчны сайдын тушаалаар, химийн бодисын зөвшөөрлийг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга олгож байхаар зохицуулалт хийлээ.

“Агаарын бохирдолын төлбөрийн тухай” хууль, “Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлж, “Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт оруулахаар Байнгын хороонд шилжүүлэв.

“Ойн тухай” хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Ойн асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын бүтэц, тогтолцоог батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн барихаар шийдвэрлэв.

УИХ-ын 2008 оны 5 дугаар тогтоолоор Увс аймгийн Түргэн уул, Цагаан шувуут, Хөвсгөл аймгийн Хорьдол сарьдагийн нурууны дархан цаазат газруудыг өргөтгөж, Баянхонгор аймгийн нутагт орших Их Богд уул орчмын газар нутгийг байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авснаар Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 323 мян.га-аар нэмэгдэж Монгол Улсын нийт газар нутгийн 14.0 хувийг хамрах боллоо.

**Усны тоо бүртгэлийн дүнг авч хэлэлцэн цаашид авах арга хэмжээг тодорхойлов.** Усны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хэрэгжүүлж Усны эх үүсвэрийн тоо, нөөц, чанар, ашигласан болон хаягдал

усны хэмжээ, бүртгэлийн улсын үзлэгийн дүнг Байгаль орчны сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцэн ширгэсэн, хорогдсон шалтгааныг судлах, түүний эрчийг сааруулах талаар эрчимжтэй ажил зохион байгуулахыг холбогдох байгууллагад үүрэг болгов.

“Усны экологи, эдийн засгийн үнэлгээ”-г Засгийн газрын 2008 оны 47 дугаар тогтоолоор баталснаар усны нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдол, учирсан хохирлыг үнэлэх, ус ашиглагч, түгээгч, хэрэглэгчдээс усны экологи-эдийн засгийн үнэлгээг мөрдөх эрх зүйн орчин бүрдэв.

“Монгол орны цөлжилтийн явц, шалтгаан, түүний эрчийг сааруулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын зорилт” болон “Усны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, цаашдын зорилт” илтгэлийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэв.

Нийтээр дагаж мөрдөхөөр батлагдсан 133 шийдвэрийг нягтлан Байгаль орчны сайд дангаараа болон бусад сайдтай хамтран баталсан 45 тушаалыг хүчингүй болгов.

Байгаль орчны сайдын тушаалаар “2008 оныг байгаль орчныг хамгаалахад Төрийн бус байгууллагын оролцоог дээшлүүлэх жил” болгон зарлаж, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих орон тооны бус зөвлөл байгуулан байгаль орчны чиглэлийн төрийн бус байгууллагуудын улсын ээвлөгөөнийг 2008 онд зохион байгуулахаар бэлтгэж байна.

Энэ ажлын хүрээнд төрийн бус байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, гэрээгээр гүйцэтгүүлэх 20 гаруй ажлын жагсаалт гарган хэрэгжүүлж эхлээд байна.

Хууль бусаар мод бэлтгэсэн 58 аж ахуйн нэгжид торгууль ногдуулж, 24 аж ахуйн нэгж, байгууллага, 20 отгийн 48 хүний үйл ажиллагааг зогсоов. Эдгээр арга хэмжээнүүдийн үр дүнд хууль бус мод бэлтгэлийн хэмжээ 20 хувиар буурах нөхцөл бүрдээд байна.

Нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах төслийн ажлын хүрээнд Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зарим айл өрхийг 33.0 мянган тонн шахмал түлшээр, Баянгол дүүргийн зарим айл өрхийг 25.0 мянган тонн үртсэн шахмал түлшээр, Хан-Уул дүүргийн зарим өрхийг цахилгаан ялтсан халаагуураар, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 1000 өрхийг гэрийн иж бүрэн дулаалгаар хангах, 8 сургууль, 6 цэцэрлэг, 50 өрхийн эмнэлгийн нам даралтын халаалтын зуухыг цахилгаан халаагуураар солих ажил хийгдэж, түүхий нүүрсний хэрэглээг 5.0 мянган тн-оор бууруулав.

**Химийн хорт бодисын бүртгэл, мэдээллийг шинэчлэн, хяналт тавих ажилд ахиц дэвшил гарав.** Нийслэл, 21 аймагт явуулсан химийн бодисын улсын үзлэг, тооллогын дүнг Байгаль орчны сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, химийн бодлого болон аюултай хог хаягдлын менежментийг төгөлдөршүүлэх 2008-2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхэллээ.

Мөнгөн ус, цианитаар бохирдсон шороог цэвэрлэх, хоргүйжүүлэх арга хэмжээний хүрээнд 10 аймгийн 25 суманд явагдсан Улсын мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны яам, Үйлдвэр худалдааны яам, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын хамтарсан шалгалтаар 56.2 га талбайд 53940м<sup>3</sup> бохирдсон шлам байгааг тогтоон хяналтад авч, хадгалалт хамгаалалтыг холбогдох байгууллагуудад хариуцуулав.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 5 байгаль хамгаалагчийг нормын хувцсаар хангаж, шинжилгээний дээж авах, иргэдийг мэдээллээр тогтмол хангаж байх үүрэгтэй байгаль хамгаалагчийн орон тоог шинээр бий болгон ажиллуулж эхлэв.

## Зургаа. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГЫН ТАЛААР

### **Батлан хамгаалах салбарт**

Батлан хамгаалахын эрх зүйн шинэтгэлийг төгөлдөршүүлэх, бодлогын хэрэгжилт, зэвсэглэл, техник, материал хэрэгслийн хангалтыг зохицуулах, батлан хамгаалах арга хэмжээний төсвийг зохистой зарцуулах зэрэг арга хэмжээг тууштай хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-г байгуулах эрх зүйн үндсийг бий болгох зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлэн дэмжүүлж, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов.

Батлан хамгаалах тухай болон Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дайны байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд эдгээр хуулиудын төслийг 2008 онд УИХ-д өргөн барьж батлуулахаар ажиллаж байна.

Иргэний цэргийн алба хаах арга хэлбэрийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор “Офицерын алба хаах журам”, “Ахлагчийн алба хаах журам”-ыг шинэчлэн боловсруулж офицер, ахлагчийн алба хаах эрх зүйн харилцааг зохицуулан баталгаажуулсны зэрэгцээ “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол”, “Иргэн цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”, “Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам” зэрэг иргэний цэргийн алба хаахтай холбоотой эрх зүйн актуудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүдийг боловсруулаад байна.

Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгагдсан 40 гаруй дэд төсөл, хөтөлбөрүүдээс 30 гаруй төсөл, хөтөлбөрийг боловсруулаад байна.

“Агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журам”, Аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврын тодотголыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн тогтоол гаргаж, аймаг, нийслэлд хүргүүлэв.

Зэвсэгт хүчний НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлж байна. Дэлхийн 8 оронд зохион байгуулагдаж байгаа энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд Зэвсэгт хүчний 400 орчим цэргийн албан хаагч, 12 цэргийн ажиглагч-офицер үүргээ нэр төртэй гүйцэтгэж байна. Зөвхөн 2008 он гарсаар Ирак дахь дайны дараах гамшгийг арилгах, сэргээн босгох, энхийг сахиулах олон улсын хүмүүнлэгийн ажиллагаанд Зэвсэгт хүчний цэргийн багийн 9 дүгээр, Сьерра-Леон Улс дахь НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд цэргийн багийн 5 дугаар ээлжийг тус тус илгээгээд байна.

ОХУ-ын Цэрэг-техникийн хамтын ажиллагааны Холбооны албаны төлөөлөгчид Монгол Улсад айлчлан цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлаар хэлэлцээ хийж, “Монгол Улсад цэрэг-техникийн тусламж үзүүлэх

тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрийн хүчинтэй хугацааг сунгаж, Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын зэвсэглэл, техникийн гэрээг шинэчлэн баталлаа. Энэхүү гэрээ батлагдсанаар 2005 онд хэрэгжүүлж эхэлсэн Монгол Улсад үзүүлэх зэвсэг, техникийн буцалтгүй тусламжийн ажил үргэлжлэх бололцоотой болж зэвсэглэл, техникийн шинэчлэлд тодорхой үр дүнгээ өгөх болно.

Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтыг “Зэвсэгт хүчний олон талт үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх хөгжлийн чиг хандлага” сэдвээр зохион байгуулан явуулсан нь удирдах бүрэлдэхүүний стратегийн сэтгэлгээ хөгжүүлэх, цэргийн шинэчлэлийг бүх шатанд хүргэхэд зохих үр дүнгээ өглөө. “Цэргийн сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх заавар”-ыг шинэчлэн батлаж, цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөж явуулах арга зүйг боловсронгуй болгох талаар сургалт-семинарыг зохион байгуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн өгсөн үүргийг хэрэгжүүлэх, Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэд, Зэвсэгт хүчний анги, байгууллагад сурталчлах 3 сарын ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, ажлын хэсгийг томилон бэлтгэл ажлыг хангаад байна. Тухайлбал, 2008 оны 3 дугаар сард Сэлэнгэ аймагт Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах юм.

### ***Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны талаар***

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 261 дүгээр тогтоолоор мал хаваржилт хүндэрч болзошгүй аймгуудад өвс, тэжээл нөөцлөх нэмэлт хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, улсын нөөцийн салбаруудад 2000 тонн өвс, 2500 тонн тэжээлийг нөөцлөх зохион байгуулалтын арга хэмжээ авч байна.

НҮБХХ-ийн “Монгол Улсад Гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” МОН/05/305 төсөлтэй хамтран “Хот суурин газрын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ” сэдэвт сургалтыг Дархан-Уул, Орхон аймгуудад зохион байгууллаа.

Улсын нөөцийн ил задгай талбайд нөөцлөгдөж буй 2007 оноос өмнө бэлтгэсэн 10354.9 тонн өвсийг үнэ төлбөргүйгээр, саравчинд хадгалагдаж байгаа 4038.9 тонн өвсний үнийг 50 хувиар, агуулахад хадгалагдаж байгаа 2482.8 тонн өвсний үнийг 20 хувиар тус тус хямдруулж, орон нутагтаа өвөлжиж, хаваржиж байгаа болон отроор яваа малчдад хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2001 оноос хойш Засгийн газрын тогтоолоор эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр иргэд, малчдад зээлээр олгогдсон 461.6 сая төгрөгийн үнэ бүхий өвс тэжээлийн өрийг чөлөөлөх шийдвэр гаргав.

Улсын нөөцийн үрийг нөхөн бүрдүүлэх зорилгоор Дархан-Уул аймаг дахь улсын нөөцийн салбараас 1800 тонн импортын үрийг Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймаг дахь салбарт тээвэрлэн байршуулах ажлыг гүйцэтгээд байна.

Улсын нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор улсын нөөцийн салбаруудад хадгалагдаж байгаа шатахууны үнийг шинэчлэн тогтоож, мөрдүүлж байна.

Өвөлжилт, хаваржилт хүндэрч болзошгүй 15 аймагт 2765 тонн өвс, 2595 тонн тэжээлийг бэлтгэхээр аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж, төлбөрийг барагдуулах арга хэмжээ авлаа.

Мал хаваржилтын байдал хүндэрч байгаа баруун бүсийн Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс аймгуудад улсын нөөцөөс 352 тн өвс, 400 тн тэжээл худалдан борлуулав. Нөөц бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотоос 100 тн тэжээл, Баянхонгор, Завхан аймгийн Улсын нөөцийн салбаруудаас дээрх аймгуудад 400 тн өвс тээвэрлэн байршууллаа.

Нийслэлийн Багануур дүүрэгт болсон архины хордлогод өртсөн иргэдийн эмчилгээнд зориулж хордлого тайлах үйлчлэлтэй 150.7 мянган төгрөгийн үнэтэй Тиосульфат натри 270 ампул, протамин 40 ампулыг тус тус Улсын нөөцөөс олгов.

Адууны халдварт ханиад өвчинд хээрийн лабораториор шинжилгээ хийж оношийг баталгаажуулан хорио цээрийн дэглэмийг тогтоов. Адууны халдварт ханиад өвчнөөр 18 аймгийн 196 сум, нийслэлийн 2 дүүргийн нутагт 384078 адуу өвчилснөөс 132 адуу хорогдож, 249328 адуу эдгэрсэн (нийт адууны 69.9%) бөгөөд одоо 14 аймгийн 140 сум, нийслэлийн 2 дүүргийн нутаг дэвсгэрт 134618 адуу тусгаарлагдан сум, багийн эмч, малчдын хяналтанд эмчлэгдэж байна. Адууны халдварт ханиад өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс аймгуудад “Биокомбинат” Төрийн өмчит улсын үйлдвэрийн газарт 80000 тун вакцин үйлдвэрлэн хүргүүлж, адууг вакцинжуулах арга хэмжээ авлаа.

Засгийн газар байгуулагдсанаас хойш аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал унтраах ангиуд 300 гаруй гал түймрийг унтраасны зэрэгцээ аврах ажиллагаа явуулж төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 1.631.9 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг нийт 2909 байгууллага, аж ахуйн нэгж, 62995 айл өрхөд хийж 35924 зөрчлийг илрүүлэн 27828 зөрчлийг шалгалтын явцад арилгуулан 680 зөрчлийг арилгуулахаар мэдэгдэл өгч, 45 объектын үйл ажиллагааг хэсэгчлэн буюу түр хугацаагаар зогсоож 130 байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 5.4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулжээ.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 82 мм-ийн миномётын тэсрээгүй сум, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт 120 мм-ийн цэнэгтэй сум илэрснийг Аврах тусгай ангийн инженерийн бүлэг, Зэвсэгт хүчний Жанжин штабын Хайгуул устгалын бүлэг газар дээр нь ажиллаж аюулгүй болгох арга хэмжээ авлаа. Монгол улсад хэрэглэхийг хориглосон 3 төрлийн пестицидийн үлдэгдлийг аймгуудаас татан авчирч Онцгой байдлын ерөнхий газрын хяналтад авахаар шийдвэрлэв.

2007 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хүчтэй цасан шуурганы улмаас Төв аймгийн Сэргэлэн, Хэнтий аймгийн Өлзийт, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Наран, Эрдэнэцагаан сум дахь Хилийн цэргийн 20 дугаар отряд, Дундговь аймгийн Сайнцагаан, Дэлгэрхангай, Ховд аймгийн Булган, Дорнод аймгийн Сэргэлэн, Баянтүмэн, Чойбалсан, Өвөрхангай аймгийн Богд, Баруунбаян-Улаан, Төгрөг сумдад сураггүй болсон 70 хүнийг Онцгой байдлын хэлтсийн албан хаагчид болон орон нутгаас томилогдсон эрлийн бүлэг эсэн мэнд олсон байна.

Долоо. ГАДААД БОДЛОГЫН ТАЛААР

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын АНЭУ, Кувейт, Катар Улсын төрийн тэргүүн нарын урилгаар 11 дүгээр сарын сүүлчээр дээрх улсуудад хийсэн төрийн айлчлалыг зохион байгуулав. Эдгээр айлчлалын үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаяр АНЭУ-ын Ерөнхийлөгч, Кувейт, Катарын Эмиртэй тус тус уулзаж, албан ёсны яриа хэлэлцээ хийв.

Монгол, Оросын харилцаа идэвхтэй явагдлаа. ОХУ-ын Буриадын БНУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-ын ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч нар Монгол улсад айлчиллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2007 оны 12 дугаар сард Монгол-Оросын бизнес форум амжилттай явагдав. Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяраас ОХУ-ын Засгийн газрын дарга В.А.Зубковт захидал илгээж, манай улсад үнийн өсөлтийг сааруулахад дэмжлэг үзүүлэх хүсэлт тавьсны дагуу ОХУ-ын Засгийн газар шуурхай арга хэмжээ авч, гурил, улаан буудайг хөнгөлөлттэй үнээр нийлүүлсэн нь манай уламжлалт цагаан сарын өмнө хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулахад чухал ач холбогдолтой болов.

УИХ-ын дарга Лүндээжанцан 2007 оны 12 дугаар сард Канад, 2008 оны 2 дугаар сард Япон Улсад айлчлав. Монгол Улсын Их Хурлын гишүүн, Гадаад хэргийн сайд С.Оюун Швейцарь, Япон Улсад айлчлав.

Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барихад Япон Улсын Засгийн газар 28,8 тэрбум иений хөнгөлөлттэй зээл олгохоор болов. Япон Улсын Засгийн газраас 800.0 сая иений төслийн бус буцалтгүй тусламж авах тухай асуудлыг шийдвэрлүүлж холбогдох ноот бичигт Гадаад хэргийн сайд, Япон улсын Элчин сайд нар гарын үсэг зурав. Японы Засгийн газрын JICE, JDS тэтгэлэгээр 2008-2009 оны хичээлийн жилд Япон улсад суралцах оюутнуудын 4 дэх шатны шалгаруулалт явуулж 32 оюутанг дараагийн шалгаруулалтад сонгов.

Австрали, Шведийн Вант Улсад Элчин сайдын яамд нээх асуудлыг УИХ-д өргөн мэдүүлж зохих шийдвэр гаргуулав.

Гадаадын 11 улсад суух элчин сайд нарын томилгооны асуудлыг УИХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлэв.

## Найм. ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ТАЛААР

Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, борлуулалт, үйлчилгээ, хэрэглээнд хяналт тавих тухай, Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын заавал даатгах даатгалын тухай, Зар сурталчилгааны тухай хуулийн төсөл болон тэдгээрийг дагаж гарах Харилцаа, холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Татварын өршөөлийн тухай, Монгол Улс, БНСУ-ын хооронд "Ялтан шилжүүлэх тухай гэрээ"-г соёрхон батлуулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон уг хуультай холбогдох багц хуулиудын төслийг

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

УИХ-д өргөн барьсан дээрхи хуулиудын төсөл батлагдсанаар уг хуулиар зохицуулах харилцаа хийгээд холбогдох хууль тогтоомжууд боловсронгуй болох ач холбогдолтой юм.

Нотариатын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Концессын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар бэлдэж байна.

2006 онд батлагдсан “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-т нийт аймаг, нийслэлийн дүүргүүдэд төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх, иргэдэд зориулан эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах чиг үүрэг бүхий “Эрх зүйн туслалцааны төв”-ийг байгуулахаар заасан бөгөөд уг төвийн дүрмийг Хууль зүй, дотоод хэргийн яам батлан аймаг, нийслэлд хүргүүлсэн байна. Одоогоор 2 аймаг, нийслэлийн 2 дүүрэгт Эрх зүйн туслалцааны төв үйл ажиллагаагаа эхлэхэд бэлэн болоод байна.

Захиргааны байгууллагуудын хүнд суртлыг багасгах, тэдгээрийн шийдвэр гаргах чадавхийг дээшлүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгох, төрийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Засгийн газар тогтоол (2007 оны 324 дүгээр тогтоол) гаргаж, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга нарт эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ хүрээнд гаргасан нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрүүдийг цэгцлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Энэ ажлын хүрээнд нийт 373 шийдвэрийг хүчингүй болгосон ба 215 шийдвэрийг хүчингүй болгохоор ажиллаж байна.

Хүн амын өрхийн болон хаягийн бүртгэл, сонгогчийн нэрсийн жагсаалтыг шинэчлэн гаргаж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, эдгээр жагсаалтыг 2008 оны 1 дүгээр улиралд багтаан гаргах ажлыг зохион байгуулах зорилгоор “Иргэний бүртгэлийг сайжруулах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2008 оны 5 тоот тогтоол гаргав. Бүртгэлийн ажлын явц 2008 оны 2 дугаар сарын 23-ны байдлаар Ховд, Дорноговь, Говьсүмбэр, Архангай, Орхон, Сүхбаатар аймагт 100, Хэнтий, Хөвсгөл, Өвөрхангай, Дорнод, Дархан-Уул, Говь-Алтай, Баянхонгор, Дундговь, Завхан аймагт 90-98.4, Булган, Баян-Өлгий, Сэлэнгэ, Увс аймаг, нийслэлд 80.6-87.7 хувьтай байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах ажлын үр дүнгийн талаарх Цагдаагийн байгууллагын мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, иргэд аюулгүй орчинд тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, таслан зогсоох зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын тогтоол (2007 оны 12 дугаар сарын 26-ны 346 тоот) гарган ажиллаж байна.

Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн амын нягтрал, хөдөлгөөн, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалтай уялдуулан нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийг 4 бүс, 50 хэсэгт хувааж цагдаагийн хөдөлгөөнт эргүүл ажиллах цэг, байршлыг шинэчлэн тогтоож 24 цагийн горимд шилжүүлэн, хөдөлгөөнт эргүүлийн нэгжид шаардагдах автомашин,

холбооны болон бусад техник, тусгай хэрэгслээр хангав. Ингэснээр цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн дуудлагад 30-50 минутад очдог байсан бол цагдаагийн хөдөлгөөнт эргүүл ажиллаж эхэлснээс хойш энэ хугацаа 5-6 дахин багасаж 5-10 минут болсон байна.

Хадгаламж зээлийн хоршооны үүсгэн байгуулагчдын буруутай үйл ажиллагаа, хадгаламж зээлийн хоршоонд мөнгөө хадгалуулсан олон иргэдэд хохирол учруулсан хууль бус үйлдэлд нь цагдаагаийн байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, улмаар шүүхийн шийдвэр гарсан 19 хадгаламж зээлийн хоршооны 5158 хохирогчийн бичиг баримт материалыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зохих журмын дагуу хүлээн авч бүртгэн гэрээ байгуулснаас 17 хадгаламж зээлийн хоршооны 3047 хохирогчдод эргэн төлөгдөх хохирлын 50 хувь болох 17.146251.512 төгрөгийг олгоод байна

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас сар бүрийн 2 дахь долоо хоногийн мягмар гариг бүрт “Нээлттэй өдөр”-ийг зохион байгуулж байхаар болсны дагуу 2008 оны 1 дүгээр сарын 15, 2 дугаар сарын 12-ны өдрийг иргэдэд нээлттэй өдөр болгон уг арга хэмжээний үеэр давхардсан тоогоор нийт 613 иргэн үйлчлүүлснээс, иргэдийн 70 хувь нь өргөдөл, гомдол, 10 хувь нь өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудлуудаар санаа зовнин санал бодлоо илэрхийлж байна. Мөн нээлттэй өдрийн хүрээнд Нотариатын танхимын нотариатч нар иргэдэд үнэ төлбөргүй үйлчилж, Өмгөөлөгчдийн холбоо хууль зүйн зөвлөгөө өгчээ.

Замын-Үүд, Алтанбулаг, Сүхбаатар, Буянт-Ухаа хилийн боомтуудад ажиллах мэргэжлийн хяналтын албадыг бэхжүүлэх, тэнд ажиллах улсын байцаагчдын орон тоог нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудлыг судалж байна. “Замын-Үүд” олон улсын боомтыг мэргэжлийн хяналтын хэмжээнд “жишиг боомт” болгохоор төлөвлөн 140.0 сая орчим төгрөг зарцуулан ажиллаж байна.

“Хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын дүрэмт хувцас хэрэглэх журам”, “Улсын хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл хийх журам”-ыг тус тус шинэчлэв. Амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 26.3.3 заалтыг хэрэгжүүлэх зорилгоор мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг дамжин өнгөрүүлэх мэдэгдлийн загварыг батлан мөрдөж эхэллээ.

Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилтын хүрээнд “Монгол шуудан” Төрийн өмчийн компани, Түлш эрчим хүчний салбарын томоохон станцууд болох 2, 3, 4 дүгээр дулааны цахилгаан станц, Налайхын дулааны цахилгаан станцад санхүүгийн шалгалт хийв. Шалгалтаар “Монгол шуудан” Төрийн өмчийн компанид 70864.3 мянган төгрөгийн төлбөр зөрчилд акт тогтоосны 4737.8 мянган төгрөгийг улсын төсөвт оруулахаар, 64096.2 мянган төгрөгийг тухайн байгууллагад төлүүлэхээр, 2030.3 мянган төгрөгийг залруулах бичилт хийлгэхээр тус тус шийдвэрлэлээ.

Улсын хэмжээнд мах, гурил, хүнсний буудай, үр нөөцөлж хадгалах боломжтой төрийн болон хувийн компанийн агуулах, зоорийн хүчин чадлыг тогтоох, хадгалагдаж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанар, аюулгүй байдлыг шалгаж, дүгнэлт гаргав. Энэхүү шалгалтад 21 аймаг, нийслэлд шалгалт хийж, мах нядалж боловсруулах 26, гурилын 33 үйлдвэр, улсын нөөцийн 5, үрийн нөөцийн 12 салбар, гурил импортлогч 7 аж ахуйн нэгж, иргэдийн агуулах, зорь, элеваторуудыг хамрууллаа.

Нийслэлийн Багануур дүүрэгт үүссэн онцгой нөхцөл байдалтай холбогдуулан ҮТЕГ, Цагдаагийн байгууллага, МҮЭХ, ХЭАХН-тэй хамтран шалгалт хийх ажлыг зохион байгуулж, архины 112, спиртийн 17 үйлдвэр, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий 12226 аж ахуйн нэгж, цэг, салбарыг хамруулж, архины 24, спитрийн 3 үйлдвэрийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох дүгнэлт гаргаад байна.

Шалгалтын явцад 12998 мэдэгдэл, зөрчил арилгуулах шаардлагыг аж ахуйн нэгж, иргэдэд хүргүүлж, биелэлтийг хангуулах арга хэмжээг авч ажилласан байна.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт 112 архины үйлдвэрээс 2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 84 үйлдвэр тоолуур суурилуулсан, 28 үйлдвэр тоолуур суурилуулаагүй, спиртийн 17 үйлдвэрээс 12 үйлдвэр хяналтын тоолуур суурилуулсан байна.

Шалгалтаар 13.0 мянга орчим аж ахуйн нэгж, байгууллагад согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдаалах, үйлчлэхийг хориглох тухай мэдэгдэл, шаардлагыг хүргүүлж, нийт 1955,9 мянган шил архийг битүүмжлэн лабораторын шинжилгээнд шилжүүлэн шалгаж байна. Шинжилгээний урьдчилсан дүнгээр нийт шинжлэгдсэн архи, спиртийн дээжийн 31.8% буюу 2241 дээж стандартын шаардлагыг хангахгүй, 0.4% буюу 30 дээжинд метилийн спиртийн хэмжээ стандартаар тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их гарсан байна.

Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа мод, модон материалын “Хангай”, “Цайз”, “Цолмонбадрах” зэрэг захууд, тэнд үйл ажиллагаа явуулж байгаа 42 түрээслэгч нарын худалдаалж буй мод, модон материалууд зохих зөвшөөрлийн дагуу бэлтгэгдсэн эсэхийг болон тэдгээрийг тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлийг шалгав. Шалгалтаар гарал үүслийн гэрчилгээгүй болон бусад зөрчилтэй 107 ш нойтон нарс, 380 м3 мод, модон материалыг улсын орлого болгон хурааж, холбогдох хуулийн дагуу 3.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авчээ.

**ЗАСГИЙН ГАЗРААС УИХ-ЫН 2008 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР  
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛҮҮДИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хууль тогтоомжийн төслийн нэр
1	Монгол Улсын 2009 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай
2	Монгол Улсын 2007 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай
3	Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаархи сонгуулийн өмнөх мэдэгдэл
4	Улсын Их Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай, зардлын хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүд
5	Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
6	Төсвийн байгууллагын удирдага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөл
7	Төсвийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/
8	Малын даатгалын тухай хуулийн төсөл
9	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/
10	Харьяатын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
11	Агаарын төлбөрийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

12	Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл
13	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
14	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
15	Үйлдвэр-хотуудын талаар авах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл
16	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
17	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн төсөл
18	Технологи дамжуулах тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/
19	Фермерийн аж ахуйн тухай хуулийн төсөл
20	Орон нутгийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
21	Үндэсний их баяр наадмын тухай /шинэчилсэн найруулга/, Үндэсний их баяр наадмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төсөл
22	Мэдээллийн технологитой холбогдсон багц хуулийн төсөл
23	Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
24	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

**ТАЙЛБАР:**

1. Энэхүү жагсаалтад “УИХ-ын 2008 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” УИХ-ын 2008 оны 15 дугаар тогтоолд тусгагдсан хууль тогтоомжийн төслийн жагсаалтад орсон болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж өргөн барихаар төлөвлөсөн бусад хууль тогтоомжийн төслүүд орсон болно.
2. УИХ-ын 2008 оны 15 дугаар тогтоолд тусгагдсан хууль тогтоомжийн төслүүдээс өмнө нь Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хууль тогтоомжийн төслийг энэ жагсаалтад оруулаагүй.

--oOo--

## Г А Р Ч И Г

<b>Нэг.</b> ТӨРИЙН УДИРДЛАГА, ИРГЭДИЙН ОРОЛЦОО	2
<b>Хоёр.</b> НИЙГМИЙН БОДЛОГЫН ТАЛААР	4
<b>Гурав.</b> ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТАЛААР	11
<b>Дөрөв.</b> ХОТ БАЙГУУЛАЛТ, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГЫН ТАЛААР	17
<b>Тав.</b> БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ТАЛААР	26
<b>Зургаа.</b> БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГЫН ТАЛААР	28
<b>Долоо.</b> ГАДААД БОДЛОГЫН ТАЛААР	31
<b>Найм.</b> ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ТАЛААР	32
ЗАСГИЙН ГАЗРААС УИХ-ЫН 2008 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛҮҮДИЙН ЖАГСААЛТ	35

С.БАЯРЫН ТЭРГҮҮЛСЭН  
ЗАСГИЙН ГАЗАР  
100  
ХОНОГТ

Эрхлэн хэвлүүлсэн:

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**  
Хяналт- шинжилгээ, үнэлгээний  
хэлтэс